



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 703

Улаанбаатар хот

Г Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус үндэслэн “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 он, 2024 оны эхний хагас жилийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 52,081,354.50 (тавин хоёр сая наян нэгэн мянга гурван зуун тавин дөрвөн төгрөг тавин мөнгө) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТӨГТООХ нь:

1.“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэр газрын 2023 он, 2024 оны эхний хагас жилийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэр газрын захирал (Г.Гансүх)-д Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, Төрийн өмчийг эзэмшиүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай;

3.Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэр газрын захирал (Г.Гансүх)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай

3.1.Үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн тухайн жилийн бизнес төлөвлөгөөг боловсруулж ажиллах;

3.2.Байгууллагын хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журмыг салбарын хамтын гэрээ, бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх, цаашид байгууллагын дотоодод мөрдөх эрх зүйн баримт бичгийн хоорондын уялдааг ханган боловсруулж мөрдүүлэн ажиллах;

3.3.Ажилчдад ээлжийн амралтын урьдчилгаа хэлбэрээр зээл олгохыг таслан зогсоох;


3.4.Батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагүй үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх.

4.Тогтоолын биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн
703 дугаар тогтоолын хавсралт



“Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчийт үйлдвэрийн
газарт хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил,
дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн /төгрөг/	Зөрчигдсөн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Ажилчдад ээлжийн амралтын урьдчилгаа хэлбэрээр зээл олгосон	38,605,000.0	Төсвийн тухай хууль, Хэмнэлтийн тухай хууль	Төсвийг зориулалтын дагуу зарцуулах
2	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн	13,476,354.5	ТБОНӨТ хуулийн 11.8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 558 дугаар тогтоол	Хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө бэлтгэхгүй байх
НИЙТ ДҮН:		52,081,354.50 (тавин хоёр сая наян нэгэн мянга гурван зуун тавин дөрвөн төгрөг тавин мөнгө)		

**“ШИНГЭН ТҮЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ”
ТӨҮГ-ЫН 2023 ОН, 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

2024 оны 12 дугаар сарын 04-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт заасныг үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөө болон баталсан удирдамжийн дагуу “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 он, 2024 оны эхний хагас жилийн байдлаарх удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга, санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч Ц.Түвшинзаяа, ахлах мэргэжилтэн, санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч Э.Ганчимэг, мэргэжилтэн санхүүгийн хяналт шалгалтын Улсын байцаагч Ч.Батчимэг нар баримтын шалгалт хийллээ.

Шалгалтаар тус байгууллагын санхүү, эдийн засаг, үйлдвэрлэл, үр ашгийн байдал, төрийн өмчийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хадгалалт, хамгаалалт, эзэмшилт, захиран зарцуулалт, хөрөнгөд бүртгэлээр тавьж буй хяналт, захиралтай байгуулсан контракт болон “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ээр хүлээсэн үүргийн хэрэгжилт явц, өр авлага түүний барагдуулалт, тооцоо нийлсэн акт, байгууллага аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээ хэлцэл, худалдан авалтын үйл ажиллагаа зэргийг шалгаж дүгнэлт гарган, илэрсэн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтнуудад мэргэжил, арга зүйн заавар, зөвлөгөө өгч ажиллав.

Шалгалтад хамрагдах хугацааны санхүүгийн баримтад дор дурдсан албан тушаалтан гарын үсгийн 1, 2 дугаарыг зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Д/д	Нэрс	Эрх бүхий албан тушаал	Томилогдсон шийдвэр, огноо
1	Г.Гансүх	Захирал	ТӨБЗГ-ЫН 2016 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 45 дугаар тогтоол “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж”
2	Б.Дэлгэрдалай	Ерөнхий нягтлан бодогч	ТӨҮГ-ЫН захирлын 2010 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 24 дүгээр тушаал

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны санхүүгийн тайланд “Ашид баланс аудит” ХХК аудит хийж, “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгчээ.

Аудитаар Нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой 1 зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн байна.


Үйлдвэрийн газар нь санхүү, нягтлан бodoх бүртгэлийн үйл ажиллагаандаа “Даймонд” програм хангамж ашиглаж байна.

**ХОЁР. ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА,
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

2.1. Байгууллагын товч танилцуулга: Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийг газрын тосны бүтээгдэхүүний импортын хоёр дахь эх үүсвэр бий болгох зорилгоор Монгол улсын Засгийн газраас Европын холбоотой хамтран ТАСИС хөтөлбөрийн хүрээнд буцалтгүй тусlamжийн хөрөнгөөр барьж, 2004 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр ашиглалтад оруулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 243 дугаар тогтоол, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны 2009 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн Б-1/2817 тоот албан бичгийг үндэслэн “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрыг байгуулжээ.

Байгууламжийн үндсэн зураг төслийг Европын холбооноос боловсруулсан төслийн дагуу ХБНГУ-ын “Прова Инженеринг” компани олон улсын API, NEFA, DIN стандартын дагуу төлөвлөн, тоног төхөөрөмжийг нийлүүлж угсралтын ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэсэн байна.



Энэхүү шилжүүлэн ачих байгууламж нь орчин үеийн технологи, тоног төхөөрөмжөөр иж бүрэн хангагдсан, үйл ажиллагааны нэгдсэн систем бүхий Европын болон олон улсын сүүлийн үеийн стандартын шаардлагад нийцсэн Монгол улсын анхны иж бүрэн газрын тосны байгууламж байна. Тухайлбал:

- Газрын тосны бүтээгдэхүүн (автобензин, дизель түлш, Жет А-1, керосин)-ийг хүлээн авах, ачих үйл ажиллагаа бүрэн автоматжуулагдсан.
- Технологийн бүх шатанд хэмжүүр, хэмжих хэрэгсэлтэй, тэдгээр нь удирдлагын төв компьютерт холбогдсон тул бүтээгдэхүүний хэмжилт, бүртгэл тооцоог компьютерээр гүйцэтгэдэг.
- Газрын тосны бүтээгдэхүүнээр байгаль орчныг бохирдуулахгүй байх хамгаалалтын системтэй.

- Галын аюулаас урьдчилан сэргийлэх, гал гарсан тохиолдолд богино хугацаанд унтраах ус, хөөсөөр хангах бүрэн автомат системтэй.
- Цахилгаан усан хангамж, холбоо зэрэг инженерийн өөрийн иж бүрэн байгууламжтай.
- Газрын тосны бүтээгдэхүүний технологи, цахилгаан хангамж, усан хангамж, гал унтраах системийг удирдах, хянах, алдаа гэмтлийг оношлох компьютерийн төв удирдлагын системтэй байна.

Байгууламжийн үндсэн үйл ажиллагаа нь БНХАУ-аас нарийн царигийн вагонцистернээр нийлүүлэгдэж байгаа газрын тосны бүтээгдэхүүн (автобензин, дизель түлш, Жет А-1, керосин)-ийг өргөн царигийн вагонцистернд шилжүүлэн ачих бөгөөд 2 цагийн хугацаанд нэгэн зэрэг 8н вагонцистернээс буулгах болон 8 вагонцистернд шилжүүлэн ачих хүчин чадалтай байна.

Тус шилжүүлэн ачих байгууламж нь газрын тосны бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, ачих зориулалттай бөгөөд дараах үндсэн тоног төхөөрөмжөөс бүрддэг байна.

- **Резервуарын парк:** Нийт 20000м3 багтаамж бүхий автобензин, дизель түлшний 6ш босоо ган савтай. Сав тус бүр нь галын аюулгүйн үүднээс хөргөлтийн болон хөөс өгөх зориулалтын шугам хоолойгоор тоноглогдсон. Паркийн далангийн дотор талд халилт асгаралтын үед газрын тосны бүтээгдэхүүнийг газрын хөрсөнд үл нэвчүүлэх зориулалттай материал дэвсэж хөрсөөр хучсан. Далангийн зүүн, баруун 2 талд гал унтраах зориулалттай хөөсний буу, баруун болон урд талд галын аюулгүйн дохиолол байрлана.

- **Насос станц:** Газрын тосны бүтээгдэхүүнийг шилжүүлэн ачих 120м3/цаг хүчин чадалтай 8ширхэг, автоцистерн ачих 20м3/цаг хүчин чадалтай 2 ширхэг насостой. Мөн вакум систем, газрын тосны бүтээгдэхүүний хувийн жинг тодорхойлох массметр, хий ангижруулагч, фильтр, хийн удирдлагатай хаалтууд байрлана. Гал унтраах төхөөрөмжөөр тоноглогдсон.

- **Вагонэстакад:** Вагонэстакад нь 2 талаараа 8,8н вагонцистерн хүлээн авах ба нарийн цариг талдаа 8ш буулгах, өргөн цариг талдаа ачих буулгах 8ш гар байрлана. Технологийн үйл ажиллагаа тус бүрийг хянах мэдрэгчүүд энд байрлах ба бүх технологийн дарааллыг үнэн зөв гүйцэтгэсэн эсэхийг хяналтын самбарт байрлах улаан, ногоон өнгийн гэрлээр мэдээлнэ. Ачилт буулгалтын үеийн үйл ажиллагааг хяналтын самбараас эхлүүлнэ. Вагонцистерн ачигдаж дүүрэхэд дүүргэлт мэдрэгч дохиолол өгснөөр ачилт буулгалтын үеийн үйл ажиллагаа автоматаар зогсоно. Гал унтраах төхөөрөмжөөр тоноглогдсон.

- **Авто ачих:** Савнаас автобензин, дизель түлшийг автоцистерн ачих зориулалттай гар байрлана. Технологийн үйл ажиллагааг Accuoload-III автоматжуулсан систем ашиглан явуулах ба автоцистернийг дүүрч халихаас сэргийлэх дүүргэлт мэдрэгчтэй. Технологийн үйл ажиллагааны дэс дараалал бүрийг хянах мэдрэгчүүд мөн энд байрлаж, дарааллыг үнэн зөв бүрэн гүйцэтгэсэн эсэхээс хамаарч ачилтын ажиллагааг эхлүүлэх зөвшөөрлийг системд өгнө.

- **Олон талт барилга:** Технологийн үйл ажиллагааг хянах, удирдах компьютер, дизель генератор, галын дизель насос, усан сан, гал унтраах системийн удирдлагын самбар, тоног төхөөрөмжийн удирдлагын паниелиуд байрлана.

- **Гал унтраах систем:** Тус байгууламж нь гал унтраах иж бүрэн автомат системтэй. Үүнд:

- Галын дохиолол
- Галын гидрантууд



- Хөөсний буу, шүршигч
- Усан сан – 600м3
- Галын дизель насос
- Гал унтраах хөөс
- Саванд хөөс өгөх болон хөргөлтийн хоолой

• **Лаборатори:** Тус лаборатори нь газрын тосны бүтээгдэхүүн (автобензин, дизель түлш, Жет А-1, керосин)-ийг өргөн царигийн вагонцистерн болон автоцистернд ачих үед хүлээн авах ба түгээлтийн үеийн, саванд хадгалах үед хадгалалтын үеийн шинжилгээг MNS болон ГОСТ, АСТМ стандартуудын дагуу хийж гүйцэтгэдэг байна.

Лаборатори нь стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023/11/27-ны TL/136 тоот тушаалаар 4 жилийн хугацаатай буюу 2027/11/26-ны өдрийг хүртэл хугацаатай итгэмжлэлийн гэрчилгээг хүлээн авсан байна. Итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтын дагуу:

Автобензинд: Хувийн жин, найрлагын бүрэлдэхүүн, зэс хавтгайн туршилт, ханасан уурын даралт, бодит давирхайн хэмжээ, усны агууламж, механик хольц, усанд уусах хүчил шүлт;

Дизель түлшинд: Хувийн жин, кинематик зууралдлага, дөл үүсэх температур битүү тигельд, найрлагын бүрэлдэхүүн, усны агууламж, механик хольц, усанд уусах хүчил шүлт;

Онгоцны бензин, ЖЕТ А-1 түлшинд, керосинд: Хувийн жин, кинематик зууралдлага, дөл үүсэх температур битүү тигельд, найрлагын бүрэлдэхүүн, зэс хавтгайн туршилт усны агууламж, механик хольц, усанд уусах хүчил шүлт зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлдог байна.

2.2. Дүрэм, чиг үүргийн талаар: “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газар нь Улсын бүртгэлийн 613001001 дугаартай гэрчилгээтэй бөгөөд үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих, хадгалах үйл ажиллагаа гэжээ. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хэсэгт Бүх төрлийн шатахууны бөөний худалдаа эрхлэх, Бүх төрлийн шатахуун импортлох үйл ажиллагааг 2020-05-28-ны өдөр нэмж шинээр бүртгэжээ.

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016-11-08-ны өдрийн 131 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан бөгөөд 2 дугаар хавсралтаар үйлдвэрийн газрын албан тушаалын жагсаалтыг баталсан байна.

Дүрэмд үйлдвэрийн газар нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж заажээ. Үүнд:

- Газрын тосны бүтээгдэхүүнийг шилжүүлэн ачих, хадгалах ажлыг гүйцэтгэх;
- Газрын тосны бүтээгдэхүүнийг шилжүүлэн ачих тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллээр холбогдох байгууллагыг хангах;
- Олон улсын чанарын стандартад нийцсэн газрын тосны бүтээгдэхүүнийг зохих журмын дагуу импортлох;
- Үйлдвэрийн газар нь хөрөнгө оруулалт хийх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, судалгаа хийх;
- Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;
- Хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх гэж заасан байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019-11-29-ний 503 дугаар тогтоолоор үйлдвэрийн газрын дүрмийн 1.2.4.2 дахь хэсэгт “....шилжүүлэн ачих, хадгалах,” гэсний дараа “импортлох, бөөний болон жижиглэн худалдаа эрхлэх” гэж, мөн 4.8.3 дахь хэсэгт “...зохих журмын дагуу импортлох, гэсний дараа “бөөний болон жижиглэн худалдаа эрхлэх” чиг үүргийг нэмж, дүрэмд тусгах зөвшөөрөл олгож, дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт зохих журмын дагуу бүртгүүлэх үүрэг өгсөн хэдий ч бүртгүүлсэн баримт байхгүй байна.

2.3.Бүтэц, зохион байгуулалтын талаар: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын албан тушаалын жагсаалтыг 28 хүний орон тоотойгоор баталсан байна. Үйлдвэрийн газар нь 2024 оны хагас жилийн байдлаар 31 ажиллагадтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Цаашид үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийн схем болон орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлуулах асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй.

Үйлдвэрийн газрын албан тушаалын жагсаалт

Д/д	Албан тушаал	Орон тоо
1	Захирал	1
2	Ерөнхий инженер	1
3	Ерөнхий нягтлан бодогч	1
4	Нярав	2
5	Аж ахуйн нярав, бичиг хэрэг	1
6	Хуулийн зөвлөх, дотоод хяналт	1
7	Технологийн инженер	1
8	Цахилгаан автоматикийн ажилтан	1
9	Тоног төхөөрөмжийн операторч	2
10	Сав, тоног төхөөрөмжийн засварчин	2
11	Сантехник	1
12	Ачигч, буулгагч	6
13	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	1
14	Лабораторийн эрхлэгч	1
15	Лабораторийн шинжээч мэргэжилтэн	3
16	Жолооч	2
17	Үйлчлэгч	1
Нийт		28

2.4. Компанид мөрдөж байгаа хууль эрхийн актууд, тэдгээрийн хэрэгжилтийн талаар: Үйлдвэрийн газар нь тайлант онуудад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Газрын тухай хууль, Авилгын эсрэг хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан журам, дүрэм, норм нормативыг баримтлан ажиллажээ.

Гүйцэтгэх захирлын тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг авч үзэхэд цаашид тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг оновчтой тодорхойлж, тушаалын заалтыг бүрэн тусгаж боловсруулахад анхаарах шаардлагатай байна. Тусламж, дэмжлэг, шагнал өгөх бүрд тухайн жилийн зорилтот түвшний тогтоолыг

үндэслэн тушаал гаргаж байгааг журамлаж дотоод журамд нэмэлт оруулж тусган, тоо хэмжээг тодорхой болгох нь зүйтэй. Тухайлбал 2023-12-28-ны өдрийн А/61 дугаар “Хөрөнгө зарцуулах тухай” тушаалаар ажилчдын хүүхдүүдэд 1,048,301 төгрөгийн бэлэг, 2023.05.31-ний өдрийн А/50 дугаар “Хөрөнгө зарцуулах тухай” тушаалаар ажилчдын хүүхдүүдэд 1,025,834 төгрөгийн бэлэг /жил бүр гардаг зардал/ олгох зардал гаргахдаа тухайн жилийн батлагдсан зорилтот тувшинд үндэслэж байна. Мөн “Захирлын зөвлөлийн ажиллах журам”-ыг тушаалын хавсралтаар батлах заалтыг тушаалд тусгаагүй гм байна.

**ГУРАВ.ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2023 ОН, 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН БАЙДЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ,
ЗОРИЛТОТ ТҮВШИН, ТҮҮНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЛААР**

3.1. 2023 оны зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар: “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчтэй үйлдвэрийн газар нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 558 дугаар тогтоолоор 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 705 дугаар тогтоолоор 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг тус тус батлуулжээ.

Тайлант 2023 онд орлогыг 3,727.10 сая төгрөгөөр, нийт зардлыг 2,878.22 сая төгрөгөөр, 763.98 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөсөнөөс хөрөнгө оруулалтын 22 арга хэмжээнд 670.87 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Үйлдвэрийн газрын 2023, 2024 оны хагас жилийн зорилтот түвшингийн биелэлт

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2023 он				2024 он			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Харьцуулалт		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Харьцуулалт	
			2023 гүйц- 2023 төл	2023 гүйц/ 2023 төл			2024 гүйц- 2024 төл	2024 гүйц/ 2024 төл		
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, түгээлт, борлуулалт										
1	Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих	тонн	90,000.00	60,768.30	(29,231.70)	67.52	72,000.00	36,650.50	50.90	(35,349.50)
1.1	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах	тонн	8,700.00	10,575.90	1,875.90	121.56	8,600.00	9,200.00	106.98	600.00
1.2	Газрын тосны бүтээгдэхүүний бөөний борлуулалт хийх	тонн	6,000.00	-	(6,000.00)	-	5,000.00	-	-	(5,000.00)
2	Нийт орлого	мян.төг	3,727,100.72	3,716,648.57	(10,452.15)	99.72	4,022,577.00	2,759,509.17	68.60	(1,263,067.83)
2.1	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	3,427,100.70	2,852,260.20	(574,840.50)	83.23	3,692,577.00	2,325,232.65	62.97	(1,367,344.35)
2.2	Дансны хүү, бусад орлого	мян.төг	300,000.00	864,388.40	564,388.40	288.13	330,000.00	434,276.52	131.60	104,276.52
3	Нийт зардал	мян.төг	2,878,229.92	2,425,665.87	(452,564.05)	84.28	3,067,355.80	1,496,579.11	48.79	(1,570,776.69)
3.1	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	483,565.40	475,153.30	(8,412.10)	98.26	534,844.00	215,786.90	40.35	(319,057.10)
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	848,870.80	1,290,982.70	442,111.90	152.08	955,221.20	1,262,930.06	132.21	307,708.86
5	Цэвэр ашиг/алдагдал	мян.төг	763,983.70	1,157,287.00	393,303.30	151.48	859,669.10	1,137,761.30	132.35	278,092.20
6	Төсвийн төлбөрт	мян.төг	694,140.80	554,911.20	(139,229.60)	79.94	805,033.80	438,651.95	54.49	(366,381.85)
8	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	316,221.10	653,645.80	337,424.70	206.71	426,345.90	-	-	(426,345.90)
9	Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	төг	0.77	0.65	(0.12)	84.42	0.76	0.54	71.05	(0.22)
10	Нийт авлага	мян.төг	-	328,363.50	328,363.50	-	-	2,054,842.80	-	2,054,842.80
11	Нийт ёлгэг	мян.төг	122,532.90	128,512.60	5,979.70	104.88	67,940.10	282,343.00	415.58	214,402.90
10.1	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	15,000.00	3,842.90	(11,157.10)	25.62	5,000.00	159,306.50	3,186.13	154,306.50
10.2	Үрт хугацаат өр төлбөр	мян.төг	107,532.90	124,669.70	17,136.80	115.94	62,940.10	123,036.50	195.48	60,096.40
11	Хөрөнгө оруулалт	мян.төг	670,874.00	366,111.10	(304,762.90)	54.57	477,030.00	48,123.00	10.09	(428,907.00)
12	Нийт ажиллагсдын тоо	хүн	38	34	(4.00)	89.47	38.00	31.00	81.58	(7.00)
13	Нийт цалингийн сан	мян.төг	1,246,449.40	1,164,750.90	(81,698.50)	93.45	1,463,901.80	788,108.90	53.84	(675,792.90)
14	Нэг ажилтны сарын дундаж цалин	мян.төг	2,733.40	2,854.80	121.40	104.44	3,210.31	4,237.14	131.99	1,026.83

Гүйцэтгэлээр 2023 онд нийт 3,716.64 сая төгрөгийн орлоготой ажиллаж, орлогын төлөвлөгөө 99.72 хувийн биелэлттэй байна. Нийт зардлын гүйцэтгэл 2,425.66 сая төгрөг болж, 452.56 сая төгрөг буюу 15.72 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант онд цэвэр ашиг төлөвлөснөөс 393.30 сая төгрөгөөр буюу 51.48 хувиар давж биелсэн нь зардлын хэмнэлттэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу өөрийн эх үүсвэрээс 366.11 сая төгрөгийг зарцуулсан байна.

Үйлдвэрийн газар нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 341 дүгээр тогтоолын дагуу 2022 оны ашгаас төлөх 653.64 сая төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

2024 оны нийт орлогыг 4,022.57 сая төгрөгөөр, нийт зардлыг 3,067.35 сая төгрөгөөр, 859.66 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөснөөс, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 477.03 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Эхний хагас жилийн гүйцэтгэлээр 2,759.50 сая төгрөгийн орлоготой, 1,496.57 сая төгрөгийн зардал гарган, 1,137.76 сая төгрөгийн цэвэр ашигтай, төлөвлөгөөтэй харьцуулахад орлогын төлөвлөгөө 68.60 хувийн, зардал 48.79 хувийн, цэвэр ашиг 132.35 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.2. Орлогын төлөвлөгөөний биелэлтийн талаар: 2023 онд нийт 3,727.10 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй ажиллахаар төлөвлөснөөс 3,716.64 сая төгрөгийн орлогын гүйцэтгэлтэй гарч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 136.7 сая төгрөг буюу 3.82 хувиар өссөн, тайлант оны төлөвлөгөөний биелэлт 99.72 хувийн гүйцэтгэлтэй байна.

2023 оны орлогын задаргаа, төлөвлөгөөгүйцэтгэл

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2023		Харьцуулалт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	гүйц-төл	гүйц/төл
1	Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих	мян.төг	1,227,272.72	828,658.04	(398,614.68)	67.52
2	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах	мян.төг	1,650,000.00	2,005,769.16	355,769.16	121.56
3	Газрын тосны бүтээгдэхүүний бөөний борлуулалт хийх	мян.төг	549,828.00	-	(549,828.00)	-
4	Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний орлого	мян.төг	15,000.00	17,833.00	2,833.00	118.89
5	Бусад орлого /харилцахын хүү, цахим тендер/	мян.төг	285,000.00	864,388.37	579,388.37	303.29
Нийт орлогын дүн			3,727,100.72	3,716,648.57	(10,452.15)	99.72

3.2.1. Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих орлогын талаар:

Үйлдвэрийн газар нь 2023 онд газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих үйл ажиллагаанаас 828.65 сая төгрөгийн орлого олсон ба орлогын төлөвлөгөөний биелэлт 67.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Дээрхи орлогыг Монгол Улсад шатахууны бизнес эрхэлдэг 7 компанийн газрын тосны бүтээгдэхүүнийг шилжүүлэн ачиснаас олсон орлого байна.

Шилжүүлэн ачих орлогын 2023 оны гүйцэтгэл

Д/д	Захиалагчийн нэр	Хэмжих нэгж	Шилжүүлэн ачилтын тоо	Хугацаа	2023 оны гүйцэтгэл /НӨАТ-гүй/	
1	"Лекс ойл" ХХК	мян.төг	2	2023-03-14 -2023-06-14	118,856.58	
2	"Монсуль" ХХК	мян.төг	1	6/14/2023	10,972.41	
3	"Ник" ХХК	мян.төг	6	2023-01-31-2023-12-11	105,945.05	
4	"Петростар" ХХК	мян.төг	4	2023-01-31-2023-12-18	52,484.55	
5	Петрохан "ХХК	мян.төг	1	2/13/2023	19,636.83	
6	"Сан петролиум" ХХК	мян.төг	3	2023-01-31-2023-12-18	29,829.19	
7	"Шунхлай" ХХК	мян.төг	19	2023-03-14-2023-12-31	490,933.42	
ГТБ шилжүүлэн ачилтын дүн				36	828,658.03	

3.2.2. Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах орлогын талаар: Үйлдвэрийн газар нь 2023 онд газрын тосны бүтээгдэхүүн хадгалалтын орлогоос нийт 2,005.76 сая төгрөгийн орлого олсон ба төлөвлөгөөтэй харьцуулахад 355.76 сая төгрөг буюу 21.56 хувиар давж биелсэн үзүүлэлттэй байна. Тайлант онд “Лекс Ойл” ХХК болон “Шунхлай” ХХК-тай гэрээ байгуулан ажиллажээ.

Бүтээгдэхүүн хадгалах орлогын гүйцэтгэл, төгрөгөөр

Гэрээний нэр	Хадгалаулагчийн нэр	Гэрээний дугаар	Хугацаа	Савны хэмжээ /м3/	Тоо хэмжээ /ширхэг/	Нэг сарын гэрээний төлбөр /НӨАТ-тэй/	Нэг сарын гэрээний төлбөр /НӨАТ-тэй/	Гүйц сар	Гүйцэтгэл 2023-12-31 /НӨАТ-тэй/
	Лекс Ойл ХХК	ХХГ-20	12	2000	2	30,000,000.00	60,000,000.00	12	720,000,000.00
			12	3000	1	45,000,000.00	45,000,000.00	12	540,000,000.00
Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах, хадгалаулах гэрээ	Лекс Ойл ХХК	ШТШАБ/2023-15	1	5000	1	56,333,333.33	56,333,333.33	1	56,333,333.33
		ШТШАБ/2023-15	1	5000	1	49,833,333.33	49,833,333.33	1	49,833,333.33
		ШТШАБ/2023-15-02	6	5000	2	65,000,000.00	130,000,000.00	6	780,000,000.00
			3	3000	479.524	700.00	1,007,000.40	1	1,007,000.40
			7	3000	1,142,377	700.00	5,597,647.30	1	5,597,647.30
	Шунхлай ХХК	B/34	20	3000	1,691.706	700.00	23,683,877.00	1	23,683,877.00
			18	3000	1,315.199	700.00	16,571,501.10	1	16,571,501.10
			22	3000	864.895	700.00	13,319,390.00	1	13,319,390.00
Дүн НӨАТ хассан нийт дүн									2,206,346,082.46
									2,005,769.16

3.2.3. Бусад орлогын талаар: Тайлант онд 882.22 сая төгрөгийн бусад орлого олсон байна. Бусад орлого нь сорилт шинжилгээний орлого, хадгаламжийн хүүгийн орлого, цахим тендерийн орлогоос бүрдэж байна.

2023 оны бусад орлогын гүйцэтгэл

Д/д	Захиалагчийн нэр	Хэмжих нэгж	2023 он	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний орлого	мян.төг	15,000.00	17,833.00
2	Хадгаламжийн хүүгийн орлого	мян.төг	285,000.00	863,614.63
3	Цахим тендерийн орлого	мян.төг	-	735.00
4	Шатахууны карт ашиглалтын хөнгөлөлт	мян.төг	-	38.73
Бусад орлогын дүн			300,000.00	882,221.36

Тайлант 2024 оны эхний хагаст нийт 2,759.50 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, орлогын гүйцэтгэл 68.6 хувьтай байна.

2024 оны эхний хагас жилийн орлогын задаргаа, төлөвлөгөөгүйцэтгэл

Д/д	Орлогын төлөвлөгөө	Хэмжих нэгж	2024			Харьцуулалт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл 2024/06/30	2024 гүйц/2024 төл	2024 гүйц/2024 төл	
1	Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих	мян.төг	981,818.18	599,735.44	61.1	(382,082.74)	
2	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах	мян.төг	1,622,727.27	1,725,497.22	106.3	102,769.94	
3	Газрын тосны бүтээгдэхүүний бөөний борлуулалт хийх	мян.төг	1,088,031.50	-	0.0	(1,088,031.50)	
4	Бусад орлого /харилцахын хүү, ГТБ-ний шинжилгээ г.м/	мян.төг	330,000.00	434,276.52	131.6	104,276.52	
Орлогын нийт дүн			4,022,576.95	2,759,509.17	68.60		

2024 онд газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих ажил үйлчилгээнээс нийт 981.81 сая төгрөгийн орлого олохоор төлөвлесэн бөгөөд эхний хагас жилийн байдлаар 61.1 хувийн гүйцэтгэлтэй, газрын тосны бүтээгдэхүүн хадгалалтаас нийт 1,622.72 сая төгрөг төлөвлөгөөн нь гүйцэтгэлээр 1,725.49 сая төгрөг буюу 106.3 хувь болж давуулан биелүүлсэн байна. Харин газрын тосны бүтээгдэхүүний

бөөний борлуулт хийх ажлаас нийт 1,088.03 сая төгрөг олохоор төлөвлөсөн хэдий ч орлогын төлөвлөгөө 100 хувь тасарсан байна. Бусад орлогын хувьд төлөвлөснөөс 31.6 хувиар давж биелсэн үзүүлэлттэй байна.

3.2.4. Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар: 2023 оны байдлаар нийтдээ 2,425.66 сая төгрөгийн зардалтай ажилласан нь төлөвлөсөн хэмжээнээс 452.56 сая төгрөг буюу 15.72 хувийн дутуу гүйцэтгэлтэй байна.

Тайлант оны гүйцэтгэлээс үзэхэд: нийт зардлын дүнд цалин хөлсний зардал 48.02 хувийг, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 30.06 хувийг, НДШ-ийн зардал 6.46 хувийг, 2.67 хувийг цахилгааны зардлууд нь нийт зардлын томоохон хувийг эзэлж байна.

Нийт зардлын задаргаа, төлөвлөгөө гүйцэтгэл

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2023 он		Эзлэх хувь	2024		Эзлэх хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Төлөвлөгөө	Гүйцэтгэл 2024/06/30	
1	Цалин хөлс	мян.төг	1,246,449.34	1,164,750.87	48.02	1,463,901.77	788,108.92	52.66
2	Шагнал урамшуулал	мян.төг	10,000.00	9,900.00	0.41	36,000.00	-	-
3	НДШ	мян.төг	168,270.66	156,605.39	6.46	197,626.74	106,210.28	7.10
4	Машин механизм, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ	мян.төг	84,000.00	11,826.13	0.48	91,494.00	43,595.15	2.91
5	Цахилгааны зардал	мян.төг	67,617.57	64,749.63	2.67	72,597.25	38,226.99	2.55
6	Албан томилотгүй баярын арга хэмжээний зардал	мян.төг	18,122.30	34,517.12	1.42	54,649.60	32,979.26	2.20
7	Бичиг хэргийн зардал	мян.төг	3,104.00	3,068.59	0.13	4,124.00	459.99	0.03
8	Элэгдлийн зардал	мян.төг	875,880.00	736,517.44	30.36	789,480.00	348,308.51	23.27
9	Шуудан холбооны зардал	мян.төг	8,580.00	6,090.51	0.25	7,960.00	2,769.95	0.19
10	Шатахууны зардал	мян.төг	40,839.74	14,550.77	0.60	40,598.75	7,237.27	0.48
11	Аж ахуйн зардал	мян.төг	6,000.00	3,024.16	0.12	6,541.85	2,460.72	0.16
12	Авто сэлбэг, масло тосол	мян.төг	8,290.00	7,923.97	0.33	23,524.40	5,069.35	0.34
13	Автомашины татвар, даатгал, агаарын бохирдол	мян.төг	3,000.00	658.84	0.03	3,000.00	543.42	0.04
14	Зам арчилтын төлбөр	мян.төг	48,960.00	43,572.50	1.80	48,960.00	11,139.39	0.74
15	Банк хоорондын бэлэн бус гүйлгээ, данс хөтөлсний шимтэл	мян.төг	180.00	180.20	0.01	240.00	92.30	0.01
16	Газрын төлбөр	мян.төг	1,200.00	1,992.15	0.08	1,200.00	1,992.15	0.13
17	Цэвэр бахир усны төлбөр	мян.төг	6,358.88	3,465.98	0.14	6,718.88	701.52	0.05
18	Хөдөлмөр хамгааллын зардал	мян.төг	37,020.10	34,318.55	1.41	35,188.70	4,204.72	0.28
19	Хэмжүүр, хэмжих хэрэгсэл баталгаажуулалтын зардал	мян.төг	1,500.00	5,029.96	0.21	4,300.00	-	-
20	Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	10,000.00	9,357.42	0.39	14,000.00	9,357.43	0.63
21	Аудитын зардал	мян.төг	18,000.00	7,200.00	0.30	18,000.00	-	-
22	Сургалт болон спорт, соёл болон түмний зардал	мян.төг	18,160.00	9,760.00	0.40	25,400.00	6,395.62	0.43
23	Байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардал	мян.төг	8,400.00	158.00	0.01	8,400.00	528.00	0.04
24	Лабораторийн итгэмжэл, тусгай зөвшөөрөлтэй холбоотой гарах зардал	мян.төг	54,600.00	2,653.45	0.11	7,850.00	-	-
25	Хөдөлмөрийн чадвар түр алдсан болон дотоод журмын дагуу олгогдох бусад тэтгэмжүүд	мян.төг	12,000.00	25,047.15	1.03	13,200.00	3,634.13	0.24
26	Санхүүгийн програмын хураамж, веб хуудас хөгжүүлэлт, ашигпалтын зардал	мян.төг	3,200.00	1,598.00	0.07	3,200.00	165.00	0.01
27	Бусад зардал /нийгмийн хариуцлагын хүрээнд хийж ажил гэх мэт/	мян.төг	90,000.00	-	-	10,560.00	-	-
28	Магадлашгүй зардал 1%	мян.төг	28,497.33	315.15	0.01	30,369.86	82,399.05	5.51
29	Үндсэн хөрөнгө данснаас кассаны гарз	мян.төг	-	67,033.94	2.76	-	-	-
30	Өдөрleg зохион байгуулах зардал	мян.төг	-	-	-	48,270.00	-	-
НИЙТ ЗАРДЛЫН ДУН			2,878,229.92	2,425,665.87	100.00	3,067,355.79	1,496,579.11	100.00

Тайлант 2023 оны зардлын гүйцэтгэлийг үзэхэд албан томилот, баярын арга хэмжээний зардлыг 90.47 хувиар, хэмжүүр, хэмжих хэрэгсэл, баталгаажуулалтын зардлыг 3 дахин, газрын төлбөрийг 66.01 хувиар, хөдөлмөрийн чадвар түр алдсан болон дотоод журмын дагуу олгогдох бусад тэтгэмжүүдийн зардлыг 108.73 хувиар

тус тус хэтрүүлсэн хэдий ч цалин, НДШ-ийн зардлыг 93.35 сая төгрөгөөр, засвар үйлчилгээний зардлыг 72.37 сая төгрөгөөр, шатахууны зардлыг 26.28 сая төгрөгөөр, нийгмийн хариуцлагын зардлыг 90.0 сая төгрөгөөр, магадлашгүй ажлын зардлыг 28.1 сая төгрөгөөр тус тус хэмнэн ажилласан нь зардлын бууралттай холбоотой байна.

2024 онд нийт зардлыг өмнөх оноос 189.12 сая төгрөгөөр буюу 6.57 хувиар өсгөж төлөвлөсөн байна. Эхний хагас жилийн зардлын гүйцэтгэлээс үзэхэд нийт зардлын 59.76 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 23.27 хувийг элэгдлийн зардал тус тус эзэлж байна.

3.2.5 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар: Үйлдвэрийн газар нь 2023 онд нийт 22 төрлийн 670.87 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийхээр төлөвлөснөөс 18 төрлийн 284.59 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг хийж гүйцэтгэжээ. 2024 онд 15 төрлийн 477.03 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийхээр төлөвлөсөн бөгөөд эхний хагас жилийн гүйцэтгэлээр 3 нэр төрлийн 48.12 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын хийж гүйцэтгэжээ. Биелэлт 10.09 хувьтай байна.

ДӨРӨВ. ТӨРИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ЭЗЭМШИЛ, АШИГЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ, ЗАХИРАН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР

4.1.2023 оны балансын үзүүлэлтийн талаар: “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын санхүүгийн тайланд 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 23,260.63 сая төгрөгийн нийт хөрөнгө бүртгэгдсэнээс 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 23,868.72 сая төгрөг болж 512.61 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар 40.18 хувь буюу 9,591.50 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө, 59,82 хувь буюу 14,277.21 сая төгрөгийн эргэлтийн бус хөрөнгө байна. Тайлант оны жилийн эцсийн байдлаар нийт эргэлтийн бус хөрөнгийн 89.75 хувь буюу 12,813.37 сая төгрөгийг үндсэн хөрөнгө, 5.73 хувь буюу 1,368.36 сая төгрөгийг биет бус хөрөнгө тус тус эзэлж байна.

2023 оны балансын үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Балансын дүн 2022.12.31	Хувийн жин /%	Балансын дүн 2023.12.31	Хувийн жин /%	Өсөлт/+/ Бууралт /-/	Хувийн жин /%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	мян.төг	4,847,081.36	20.84	2,557,770.21	10.72	(2,289,311.15)	26.67
Авлага	мян.төг	284,290.78	1.22	328,363.43	1.38	44,072.65	3.42
Бараа материал	мян.төг	250,925.84	1.08	271,266.74	1.14	20,340.90	2.83
Бусад санхүүгийн хөрөнгө	мян.төг	3,252,857.34	13.98	6,416,108.77	26.88	3,163,251.43	66.89
Урьдчилж гарсан зардал/тооцоо	мян.төг	24,552.80	0.11	18,000.00	0.08	(6,552.80)	0.19
Эргэлтийн хөрөнгийн дүн	мян.төг	8,669,708.12	37.23	9,691,509.15	40.18	931,801.03	100.00
Үндсэн хөрөнгө	мян.төг	13,214,047.98	56.81	12,813,376.54	53.68	(400,671.44)	89.75
Биет бус хөрөнгө	мян.төг	1,386,878.57	5.96	1,368,360.40	5.73	(18,518.17)	9.58
Хойшлогдсон татварын хөрөнгө	мян.төг	-	-	95,475.49	0.40	95,475.49	0.67
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	мян.төг	14,600,926.55	62.77	14,277,212.43	59.82	(323,714.12)	100.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	мян.төг	23,260,634.67	100.00	23,868,721.58	100.00	608,086.91	200.00
Дансны өглөг	мян.төг	33,784.54	0.15	3,842.90	0.02	(29,941.64)	1.48
Урьдчилж орсон орлого	мян.төг	-	-	131,530.86	0.55	131,530.86	50.58
Нөөц	мян.төг	12,577.19	0.05	-	-	(12,577.19)	-
Богино хугацаат өр төлберийн дүн	мян.төг	46,361.73	0.20	135,373.76	0.57	89,012.03	52.06
Хойшлогдсон татварын өр	мян.төг	107,532.96	0.46	124,669.70	0.52	17,136.74	47.94
Урт хугацаат өр төлберийн дүн	мян.төг	107,532.96	0.46	124,669.70	0.52	17,136.74	47.94
Өр төлберийн нийт дүн	мян.төг	153,894.69	0.66	260,043.46	1.09	106,148.77	100.00
Өмч: Терийн	мян.төг	15,362,339.05	66.04	15,362,339.05	64.36	-	65.07
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	мян.төг	535,186.52	2.30	533,483.44	2.24	(1,703.08)	2.26
Хуримтлагдсан ашиг	мян.төг	7,209,214.41	30.99	7,712,855.62	32.31	503,641.21	32.67
Эздийн өмчийн дүн	мян.төг	23,106,739.98	99.34	23,608,678.11	98.91	501,938.13	100.00
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	мян.төг	23,260,634.67	100.00	23,868,721.57	100.00	608,086.90	-

2023 оны жилийн эцсийн байдлаар нийт эргэлтийн хөрөнгийн 10.72 хувийг мөнгөн хөрөнгө, 1.38 хувийг авлага, 1.14 хувийг бараа материал, 26.88 хувийг бусад санхүүгийн хөрөнгө, 0.08 хувийг урьдчилж төлсөн зардал/тооцоо тус тус эзэлж байна. Эргэлтийн бус хөрөнгийн дүнд 53.68 хувь нь үндсэн хөрөнгө, 5.73 хувь нь биет бус хөрөнгө байна.

Тайлант оны эцсийн байдлаар өр төлбөр ба эзэмшигчийн дүнд 0.57 хувийг богино хугацаат өр төлбөр, 0.52 хувийг урт хугацаат өр төлбөр, 98.91 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байна.

Нийт хөрөнгийн 32.31 хувь буюу 7,712.85 сая төгрөгийг хуримтлагдсан ашиг эзэлж байна.

2024 оны хагас жилийн байдлаарх балансын үзүүлэлтийн талаар:

Үйлдвэрийн газрын санхүүгийн тайландаа 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 23,868.72 сая төгрөгийн хөрөнгө бүртгэгдсэнээс 2024 оны хагас жилийн байдлаар 25,028.78 сая төгрөг болж 1,160.06 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. 2024 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт хөрөнгийн 44.19 хувь буюу 11,060.75 сая төгрөгийг эргэлтийн хөрөнгө, 55.81 хувь буюу 13,968.03 сая төгрөгийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна.

2024 оны эхний хагас жилийн байдлаарх балансын үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Bалансын дүн 2023.12.31	Хувийн жин %/	Bалансын дүн 2024.06.30	Хувийн жин %/	Өсөлт/I+	Хувийн Бууралт I-/ жин %/
		2023.12.31	Хувийн жин %/	2024.06.30	Хувийн жин %/	Бууралт I-/	Хувийн жин %/
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	мян.төг	2,557,770.21	10.72	2,442,002.83	9.76	(115,767.38)	26.67
Авлага	мян.төг	328,363.43	1.38	2,054,842.83	8.21	1,726,479.40	3.42
Бараа материал	мян.төг	271,266.74	1.14	287,032.55	1.15	15,765.81	2.83
Бусад санхүүгийн хөрөнгө	мян.төг	6,416,108.77	26.88	6,254,105.53	24.99	(162,003.24)	66.89
Урьдчилж гарсан зардал/тооцоо	мян.төг	18,000.00	0.08	22,766.42	0.09	4,766.42	0.19
Эргэлтийн хөрөнгийн дүн	мян.төг	9,591,609.15	40.18	11,060,750.16	44.19	1,469,241.01	100.00
Үндсэн хөрөнгө	мян.төг	12,813,376.54	53.68	12,550,098.95	50.14	(263,277.59)	89.75
Биет бус хөрөнгө	мян.төг	1,368,360.40	5.73	1,331,452.50	5.32	(36,907.90)	9.58
Хойшлогдсон татварын хөрөнгө	мян.төг	95,475.49	0.40	86,480.73	0.35	(8,994.76)	0.67
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	мян.төг	14,277,212.43	59.82	13,968,032.18	55.81	(309,180.25)	100.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	мян.төг	23,868,721.58	100.00	25,028,782.34	100.00	1,160,060.76	-
Дансны ялгэг	мян.төг	3,842.90	0.02	29,024.26	0.12	25,181.36	1.48
Урьдчилж орсон орлого	мян.төг	131,530.86	0.55	126,272.23	0.50	(5,258.63)	50.58
Нөөц	мян.төг	-	-	4,009.98	0.02	4,009.98	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	мян.төг	135,373.76	0.57	159,306.47	0.64	23,932.71	52.06
Хойшлогдсон татварын өр	мян.төг	124,669.70	0.52	123,036.51	0.49	(1,633.19)	47.94
Үрт хугацаат өр төлбөрийн дүн	мян.төг	124,669.70	0.52	123,036.51	0.49	(1,633.19)	47.94
Өр төлбөрийн нийт дүн	мян.төг	260,043.46	1.09	282,342.98	1.13	22,299.52	100.00
Өмч: Төрийн	мян.төг	15,362,339.05	64.36	15,362,339.04	61.38	(0.01)	65.07
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	мян.төг	533,483.44	2.24	533,483.44	2.13	-	2.26
Хуримтлагдсан ашиг	мян.төг	7,712,855.62	32.31	8,850,616.88	35.36	1,137,761.26	32.67
Зэдийн өмчийн дүн	мян.төг	23,608,678.11	98.91	24,746,439.36	98.87	1,137,761.25	100.00
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	мян.төг	23,868,721.57	100.00	25,028,782.34	100.00	1,160,060.77	-

2024 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт эргэлтийн хөрөнгийн дүнд 26.67 хувь буюу 2,442.00 сая төгрөгийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 66.89 хувь буюу 6,254.10 сая төгрөгийг бусад санхүүгийн хөрөнгө, 3.42 хувь буюу 2,054.84 сая төгрөгийг авлага, 2.83 хувь буюу 287.03 сая төгрөгийг бараа материал 0.19 хувь буюу 22.76 сая төгрөгийг урьдчилж гарсан зардал/тооцоо данс тус тус эзэлж байна.

Харин эргэлтийн бус хөрөнгийн дүнд 89.75 хувь буюу 12,550.09 сая төгрөгийг үндсэн хөрөнгө, 9.58 хувь буюу 1,331.45 сая төгрөгийг биет бус хөрөнгө тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд өр төлбөр ба эзэмшигчийн дүнд 0.64 хувийг богино хугацаат өр төлбөр, 0.49 хувийг урт хугацаат өр төлбөр, 98.87 хувийг эзэмшигчийн өмчийн дүн эзэлж байна. Нийт хөрөнгийн 35.36 хувь буюу 8,850.61

Төхөх

сая төгрөгийг хуримтлагдсан ашиг эзэлж байна.

4.2. Мөнгөн хөрөнгийн талаар: Санхүүгийн тайлангийн 2023 оны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,847.1 сая төгрөг байсан бол тайлант хугацаанд 12,245.1 сая төгрөгийн дебет гүйлгээ хийж, 14,534.4 сая төгрөгийн кредит гүйлгээ хийж, жилийн эцсийн байдааар 2,557.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Нийт мөнгөн зарлагын 0.16 хувь нь кассаар хийгджээ.

Үйлдвэрийн газрын 2023 оны мөнгөн хөрөнгийн мэдээлэл

Дансны мэдээлэл		Хэмжих нэгж	Эхний үлдэгдэл /2023.01.01/	Гүйлгээ		Эцсийн үлдэгдэл 2023.12.31	Хувийн жин
				Дебет	Кредит		
Kass	Касст байгаа	1001-00-000-000	мян.төг	3,264.7	20,250.0	22,570.4	944.2 0.04%
Голомт банк		1101-00-000-001	мян.төг	1,306,905.5	2,327,862.2	3,042,820.8	591,946.9 23.14%
Төрийн банк		1101-00-000-002	мян.төг	30,793.9	2,093,435.6	2,122,392.3	1,837.2 0.07%
Харилцах /төгрөг/	Хас банк	1101-00-000-003	мян.төг	331.5	0.0	12.0	319.5 0.01%
Хан банк		1101-00-000-006	мян.төг	3,222,270.5	3,407,905.6	5,346,546.1	1,283,630.0 50.19%
Худалдаа, хөгжлийн банк		1101-00-000-011	мян.төг	283,515.3	4,395,591.5	4,000,014.5	679,092.3 26.55%
Хадгаламж	Төрийн банк	1101-00-000-013	мян.төг	0.0	2,158,586.1	2,158,586.1	0.0 0.00%
Нийт дун				4,847,081.4	14,403,631.1	16,692,942.3	2,557,770.2 100%

Нийт мөнгөн хөрөнгийн 0.04 хувь нь касс, үлдэх 99.96 хувь нь харилцах дансны үлдэгдэл байна.

2024 оны эхний хагас жилийн эцсийн байдаарх харилцах дансны үлдэгдлийн 50.2 хувь буюу 1,283.6 сая төгрөг нь ХААН банк, 23.1 хувь буюу 591.6 сая төгрөг нь Голомт банк, 26.6 хувь буюу 679.1 сая төгрөг нь ХХБ-ны, үлдэх 0.08 хувь буюу 2.2 сая төгрөг нь Төрийн банк, Хас банкны үлдэгдэл байна.


Үйлдвэрийн газрын 2024 оны мөнгөн хөрөнгийн мэдээлэл

Дансны мэдээлэл		Хэмжих нэгж	Үлдэгдэл 2024.01.01	Гүйлгээ		Үлдэгдэл 2024.06.31	Хувийн жин
				Дебет	Кредит		
Kass	Касст байгаа төгрөг	1001-00-000-000	мян.төг	944.2	9,835.7	9,922.6	857.4 0.04%
Голомт банк		1101-00-000-001	мян.төг	591,946.9	3,022,741.3	3,417,823.8	196,864.4 8.06%
Төрийн банк		1101-00-000-002	мян.төг	1,837.2	5,233,235.7	3,000,233.6	2,234,839.4 91.52%
Харилцах /төгрөг/	Хас банк	1101-00-000-003	мян.төг	319.5	284,245.5	284,565.0	0.0 0.00%
Хан банк		1101-00-000-006	мян.төг	1,283,630.0	616,473.5	1,892,013.1	8,090.4 0.33%
Худалдаа, хөгжлийн банк		1101-00-000-011	мян.төг	679,092.3	4,019,009.6	4,696,750.7	1,351.2 0.06%
Нийт дун				2,557,770.2	13,185,541.3	13,301,308.7	2,442,002.8 100%

Нийт мөнгөн хөрөнгийн 2024 оны эхний хагас жилийн эцсийн үлдэгдэл нь өмнөх 2023 оны жилийн эцсийн үлдэгдэл дүнгээс 115.8 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Хадгаламжийн талаар: “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ нь байгууллагын чөлөөт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг хадгалах банкийг сонгон шалгаруулалт хийж сонгосон бөгөөд хадгаламжийн хүүг хамгийн өндөр, зардал багатай, эрсдэлгүй байх шалгуур үзүүлэлтийг харгалзсан байна.

Хадгаламжийн дансны хувьд 2023 онд ХХБ-ны 45478193 дансыг 2023.01.13-нд, Төрийн банкны 280501887399 дансыг 2023.11.30-нд шинээр нээсэн бол 2023 онд Төрийн банкны 280501861689 дугаартай дансыг 2023.05.08-нд, ХААН банкны 5374617862 дугаартай дансыг 2023.01.03-д тус тус хаасан бол 2024 онд ХХБ-ны 45478193 дансыг 2024.01.12-нд, Хас банкны 5002775925 дансыг 2024.03.07-нд, Төрийн банкны 280501887399 дансыг 2024.05.28-д тус тус хаасан хөдөлгөөн хийгдсэн байна. Тус үйлдвэрийн газрын 2023 оны жилийн эцсийн байдаарх нийт



хадгаламжийн 62 хувь нь Худалдаа хөгжлийн банканд, 33 хувь нь төрийн банкинд үлдэх 4 хувь нь Хас банкны хадгаламжийн дансанд хадгалагдаж байна.

Үйлдвэрийн газрын 2023 оны хадгаламжийн мэдээлэл

Банкны нэр	Дансны дугаар	Хэмжих нэгж	Үлдэгдэл 2023.01.01	2023 онд төвлөрүүл-сэн /шинэ нээсэн/	Орлого /хүү/	Зарлага /татвар/	Зарлага /бусад/	Үлдэгдэл 2023.12.31	Хадгалж эхэлсэн огноо	Хадгаламжийн данс хаасан огноо	Өөрчлөлт	Хувийн жин
ХХБанк	454078193	сая.төг	-	4,000.0	626.7	62.7	564.0	4,000.0	1/13/2023	1/12/2024	4,000.0	62%
Хас банк	5002775925	сая.төг	252.9	-	26.7	2.7	-	276.9	3/1/2019	3/7/2024	24.0	4%
Төрийн банк	280501867399	сая.төг	-	2,121.0	20.3	2.0	-	2,139.2	11/30/2023	5/28/2024	2,139.2	33%
Төрийн банк	280501861689	сая.төг	2,000.0	-	79.3	-	2,079.3	-	11/10/2022	5/8/2023	(2,000.0)	0%
Хаан банк	5374617862	сая.төг	1,000.0	-	83.0	8.3	1,074.7	-	1/4/2022	1/3/2023	(1,000.0)	0%
НИЙТ			3,252.9	6,121.0	835.9	75.7	3,718.0	6,416.1			3,163.3	100%

Хадгаламжийн хөдлөл өөрчлөлтийг авч үзвэл 2023 оны жилийн эхэнд 3 банкинд 3,252.9 сая төгрөгийн хадгаламжтай байсан бол ХХБ-д 4.0 тэрбум, Төрийн банкинд 2.1 тэрбум нийт 6,121.0 сая төгрөгийн хадгаламж шинээр нээж, ХААН банкны 1.0 тэрбум, Төрийн банкны 2.0 тэрбум төгрөгийн хадгаламжийг хааж, жилийн эцсийн байдлаар нийт 835.9 сая төгрөгийн хүүний орлого олж, татварт 75.7 сая төгрөг төлж, 0.7 сая төгрөгийн бусад холбогдох зардал гарган 2023 оны жилийн эцэст нийт хадгаламж 3,163.3 сая төгрөгөөр өсөж, ХХБ, Хас банк, Төрийн банкинд нийт 6,416.1 сая төгрөгийн хадгаламжийн үлдэгдэлтэй болсон байна. Харин 2024 оны эхний хагас жилийн байдлаар үйлдвэрийн газрын нийт хадгаламжийн 50 хувь Голомт банкинд, 34 хувь Хас банкинд, үлдэх 16 хувь нь ХХБ-ны хадгаламжийн дансанд хадгалагдаж байна.

Үйлдвэрийн газрын 2024 оны хадгаламжийн мэдээлэл

Банкны нэр	Дансны дугаар	Хэмжих нэгж	Үлдэгдэл 2024.01.01	2024 онд төвлөрүүлсэн /шинэ нээсэн/	Орлого /хүү/	Зарлага /татвар/	Зарлага /бусад/	Үлдэгдэл 2024.06.30	Хадгалж эхэлсэн огноо	Хадгаламжийн данс хаасан огноо	Өөрчлөлт	Хувийн жин
ХХБанк	454078193	сая.төг	4,000.0	-	19.5	2.0	4,017.6	-	1/13/2023	1/12/2024	(4,000.0)	16%
ХХБанк	454091431	сая.төг	-	1,000.0	-	-	-	1,000.0	1/16/2024	7/16/2024	1,000.0	0%
Хас банк	5002775925	сая.төг	276.9	-	7.8	0.8	283.9	-	3/1/2019	3/7/2024	(276.9)	34%
Голомт банк	1915147645	сая.төг	-	2,000.0	108.7	10.9	-	2,097.8	1/16/2024	7/16/2024	2,097.8	50%
Төрийн банк	280501868096	сая.төг	-	3,000.0	173.7	17.4	-	3,156.3	1/16/2024	7/16/2024	3,156.3	0%
Төрийн банк	280501867399	сая.төг	2,139.2	-	103.9	10.4	2,232.8	-	11/30/2023	5/28/2024	(2,139.2)	
НИЙТ			6,416.1	6,000.0	413.6	41.4	6,534.2	6,254.1			(162.0)	100%

Хадгаламжийн хөдлөл өөрчлөлтийг авч үзвэл 2024 оны жилийн эхэнд 3 банкинд 6,416.1.9 сая төгрөгийн хадгаламжтай байсан бол эхний хагас жилийн байдлаар ХХБ, Голомт, Төрийн банкинд 6,000.0 сая төгрөгийн хадгаламж шинээр нээж, 2 данс хааж, нийт 413.6 сая төгрөгийн хүүний орлого олж, татварт 41.4 сая төгрөг төлж, 4,534.1 сая төгрөгийн бусад холбогдох болон хадгаламж хаасан зардал гарган 2024 оны эхний хагас жилийн байдлаар ХХБ, Голомт банк, Төрийн банкинд нийт 6,254.1 сая төгрөгийн хадгаламжийн үлдэгдэлтэй болж нийт хадгаламж 162.0 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Тус үйлдвэрийн газрын хувьд мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг илүү үр ашигтай, бүтээмжтэй байхаар эргэлтэд оруулах нь зүйтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 341 дүгээр тогтоолын дагуу “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ нь 2022 оны цэвэр ашгаас 653.6 сая төгрөгийн ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

4.3. Авлагын талаар: “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ нь 2023 оны эцэст 328.36 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байсан бол 2024 оны

эхний хагас жилийн байдлаар авлагын үлдэгдэл 2,054.8 сая төгрөгт хүрч өссөн байна. Энэ нь газрын тосны бүтээгдэхүүн хадгалалтын төлбөр болох 1,836.0 сая төгрөгийг “Лекс ойл” ХХК нь 2024 оны 09 дүгээр сард төвлөрүүлсэнтэй холбоотой үүсчээ.

Үйлдвэрийн газрын 2023, 2024 оны эхний хагас жилийн авлагын мэдээлэл

Авлагын төрөл	Хэмжих нэгж	Үлдэгдэл 2022.12.31	Үлдэгдэл 2023.12.31	Зөрүү	Хувийн жин %/	Үлдэгдэл 2024.06.30	Зөрүү
Дансны авлага	мян.төг	-	38,865.11	38,865.11	11.84	1,836,431.20	1,797,566.09
ААНОАТ-ын авлага	мян.төг	145,960.79	142,589.78	(3,371.01)	43.42	68,244.60	(74,345.18)
НӨАТ-ын авлага	мян.төг	131,630.42	13,055.79	(118,574.63)	3.98	150,167.03	137,111.24
ХАОАТ-ын авлага	мян.төг	6,473.55	2,095.86	(4,377.69)	0.64	-	(2,095.86)
Бусад татварын авлага	мян.төг	226.02	226.02	-	0.07	-	(226.02)
Хүүгийн авлага	мян.төг	-	131,530.86	131,530.86	40.06	-	(131,530.86)
Нийт авлага		284,290.78	328,363.42	44,072.64	100.00	2,054,842.83	1,726,479.41

Хүснэгтээс хараад 38.86 сая төгрөгийн дансны авлагыг нэмж бүртгэсэн нь 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрүүдэд арилжааны банкны гүйлгээ хаагдсан өдрүүдэд хийгдсэн ажил, үйлчилгээ болох газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачилт, шинжилгээний төлбөрийг бүртгэсэн байна. НӨАТ-ын авлага буурсан нь НӨАТ-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.56 заалтын дагуу хойшлогдсон татварын хөрөнгө дансанд урт хугацаагаар хувь тэнцүүлэн запруулах бичилт хийсэн байна. Мөн арилжааны банкуудад байршуулсан мөнгөн хөрөнгийн хугацаатай хадгаламжийн гэрээний дагуу 2024 онд авах 131.53 сая төгрөгийн хүүгийн авлагуудыг нэмж бүртгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсээрх авлагын 43.42 хувь буюу 142.58 сая төгрөгийг ААНОАТ-ын авлага, 40.06 хувь буюу 131.53 сая төгрөгийг хүүгийн авлага, 11.84 хувь буюу 38.86 сая төгрөгийг дансны авлага, 3.98 хувь буюу 13.05 сая төгрөгийг НӨАТ-ын авлага, 0.64 хувь буюу 2.09 сая төгрөгийг ХАОАТ-ын авлага, 0.07 хувь буюу 0.22 сая төгрөгийг бусад татварын авлага тус тус эзэлж байна.

4.4. Бараа материалын талаар: Үйлдвэрийн газар нь 2022 оны эцэст 250.92 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол тайлант оны эцэст 20.34 сая төгрөгөөр өсч 271.26 сая төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна. 2023 оны жилийн эцсээрх бараа материалын үлдэгдлийн 55.67 хувь буюу 151.01 сая төгрөгийг багаж хэрэгсэл, 21.56 хувь буюу 58.48 сая төгрөгийг засварын материал, 19.24 хувь буюу 52.18 сая төгрөгийн бараа материалыг хөдөлмөр хамгаалал, 2.18 буюу 5.92 сая төгрөгийг бичиг хэргийн материал, 0.83 хувь буюу 2.24 сая төгрөгийг цэвэрлэгээний материал, 0.52 хувь буюу 1.42 сая төгрөгийг хөдөлмөр хамгаалалын материал тус тус эзэлж байна.

Үйлдвэрийн газрын бараа материалын төрөл, хөдөлгөөн

Бараа материалын төрөл	Үлдэгдэл 2022.12.31		Орлого		Зарлага		Үлдэгдэл 2023.12.31		Эзлэх хувь 2023.12.31	
	Тоо хэмжээ /ширхэг/	Өртөг /мян.төг/								
Засварын материал	425.00	26,193.77	2,176.00	89,253.59	2,528.00	56,960.63	73.00	58,486.74	32,292.96	21.56
Аж ахуй, хоолны материал	-	-	512.45	2,221.66	512.45	2,221.66	-	-	-	-
Багаж хэрэгсэл	4,651.60	145,993.31	302.00	9,850.75	20.00	4,833.41	4,933.60	151,010.65	5,017.34	55.67
Бичиг хэргийн материал	876.50	6,470.04	1,084.00	2,113.74	1,011.30	2,661.23	949.20	5,922.55	(547.49)	2.18
Цэвэрлэгээний материал	274.15	1,947.08	298.00	2,016.28	338.75	1,720.51	233.40	2,242.85	295.77	0.83
Шатах тослох материал	172.00	766.71	5,602.17	17,048.04	5,393.66	16,391.72	380.51	1,423.04	656.33	0.52
Хөдөлмөр хамгаалал	6,363.00	69,554.92	2,081.61	7,700.05	4,057.61	25,074.05	4,387.00	52,180.92	(17,374.00)	19.24
Нийт дун	12,762.25	260,925.84	12,056.23	130,204.10	13,861.77	109,863.19	10,956.71	271,266.75	20,340.91	100.00

Бараа материалын үлдэгдэл 2024 оны эхний хагаст 287.03 сая төгрөг болж 15.76 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд худалдан авсан бараа материалын үлдэгдэл нөлөөлжээ.

4.5. Эргэлтийн бус хөрөнгийн талаар: “Шингэн түлш шилжүүлэн ачих төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын балансын дүнгээр 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт хөрөнгийн 40.18 хувь нь эргэлтийн хөрөнгө, 59.82 хувь нь эргэлтийн бус хөрөнгө эзэлж байна.

Тайлант оны жилийн эцсийн байдлаар нийт эргэлтийн бус хөрөнгийн цэвэр дүнгээрх 13,214.04 сая төгрөг буюу 90.50 хувийг биет хөрөнгө /цаашид үндсэн хөрөнгө гэнэ/, 1,386.87 сая төгрөг буюу 9.50 хувийг биет бус хөрөнгө, үлдсэн хувийг бусад хойшлогдсон татварын хөрөнгө бүрдүүлж байна.

2024 оны эхний хагасын байдлаар нийт эргэлтийн бус хөрөнгийн цэвэр дүнгээр 89.85 хувийг үндсэн хөрөнгө, 9.53 хувийг биет бус хөрөнгө тус тус эзэлж байна.

Үйлдвэрийн газрын эргэлтийн бус хөрөнгийн төрөл

Эргэлтийн бус хөрөнгийн ангилал	Хэмжих нэгж	Балансын дүн 2022.12.31	Балансын дүн 2023.12.31	Өсөлт/+/ Бууралт/-/	Хувийн жин %/	Балансын дүн 2024.06.30	Хувийн жин %/
Үндсэн хөрөнгийн балансын дүн	мян.төг	18,798,357.79	18,855,453.55	57,095.76	91.29	18,903,075.96	91.34
Үндсэн хөрөнгийн элэгдлийн дүн	мян.төг	5,584,309.82	6,042,077.02	457,767.20	94.73	6,352,977.02	94.45
Үндсэн хөрөнгийн цэвэр дүн	мян.төг	13,214,047.97	12,813,376.53	(400,671.44)	89.75	12,550,098.94	89.85
Биет бус хөрөнгийн балансын дүн	мян.төг	1,713,415.96	1,704,276.53	(9,139.43)	8.25	1,704,777.16	8.24
Хуримтлагдсан хорогдлын дүн	мян.төг	326,537.38	335,916.13	9,378.75	5.27	373,324.66	5.55
Биет бус хөрөнгийн цэвэр дүн	мян.төг	1,386,878.58	1,368,360.40	(18,518.18)	9.58	1,331,452.50	9.53
Бусад хөрөнгийн балансын үнэ	мян.төг	-	95,475.48	95,475.48	0.46	86,480.72	0.42
Хуримтлагдсан хорогдлын дүн	мян.төг	-	-	-	-	-	-
Бусад хөрөнгийн цэвэр дүн	мян.төг	-	95,475.48	95,475.48	0.67	86,480.72	0.62
Нийт эргэлтийн бус хөрөнгийн балансын дүн	мян.төг	20,511,773.75	20,655,205.56	143,431.81	100.00	20,694,333.84	100.00
Нийт эргэлтийн бус хөрөнгийн элэгдлийн дүн	мян.төг	5,910,847.20	6,377,993.15	467,145.95	100.00	6,726,301.68	100.00
Нийт эргэлтийн бус хөрөнгийн цэвэр дүн	мян.төг	14,600,926.55	14,277,212.41	(323,714.14)	100.00	13,968,032.16	100.00

Эргэлтийн бус хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар тооцдог ба эргэлтийн бус хөрөнгөд 2023 оны жилийн эцсээр 30.88 хувийн элэгдэл хорогдуулалт тооцсон байна. Үүнээс үндсэн хөрөнгөд 32.04 хувийн элэгдэл, биет бус хөрөнгөд 19.71 хувийн хорогдуулалт тооцсон байна.

4.6. Үндсэн хөрөнгийн талаар: “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ 2023 оны эхэнд 18,798.35 сая төгрөгийн балансын үнэтэй, 5,584.30 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 13,214.04 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгөтэй байсан бол тайлант онд 328.38 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, 271.28 сая төгрөгийн хөрөнгө хасагдаж оны эцэст 18,855.45 сая төгрөгийн балансын үнэтэй, 6,042.07 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 12,813.37 сая төгрөгийн үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгөтэйгээр үйл ажиллагаа явуулсан байна.

Үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгийн данс нь барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, компьютер бусад хэрэгсэл 5 данснаас бүрдэж байна.

Үйлдвэрийн газрын 2023, 2024 оны хагас жилийн байдлаар үндсэн хөрөнгийн ангилаал

Үндсэн хөрөнгийн ангилаал	Хэмжих нэгж	Үлдэгдэл 2022.12.31	Үлдэгдэл 2023.12.31	Үлдэгдэл 2024.06.30	Өсөлт /-/ Бууралт /-/	Эзлэх хувь 2024.06.30
Барилга байгууламжийн балансын үнэ	мян.төг	10,423,664.08	10,558,412.96	10,604,580.92	46,167.96	56.10
Хуримтлагдан элэгдэл	мян.төг	2,425,205.47	2,731,615.16	2,873,381.24	141,766.08	45.23
Барилга байгууламжийн цэвэр дүн	мян.төг	7,998,458.61	7,826,797.80	7,731,199.68	(95,598.12)	61.60
Машин тоног төхөөрөмжийн балансын үнэ /компьютер/	мян.төг	7,677,461.54	7,575,183.62	7,575,183.63	0.01	40.07
Хуримтлагдан элэгдэл	мян.төг	2,893,815.79	2,979,924.78	3,117,323.15	137,398.37	49.07
Машин тоног төхөөрөмжийн цэвэр дүн	мян.төг	4,783,645.75	4,595,258.84	4,457,860.48	(137,398.36)	35.52
Тээврийн хэрэгсэл балансын үнэ	мян.төг	570,763.46	580,548.12	580,548.13	0.01	3.07
Хуримтлагдан элэгдэл	мян.төг	191,788.96	250,425.53	277,126.24	26,700.71	4.36
Тээврийн хэрэгслийн цэвэр дүн	мян.төг	378,974.50	330,122.59	303,421.89	(26,700.70)	2.42
Тавилга эд хогшлын балансын үнэ	мян.төг	126,468.71	134,808.85	136,263.31	1,454.46	0.72
Хуримтлагдан элэгдэл	мян.төг	73,499.60	79,927.20	84,833.21	4,906.01	1.34
Тавилга эд хогшлын цэвэр дүн	мян.төг	52,969.11	54,881.65	51,430.10	(3,451.55)	0.41
Бусад үндсэн хөрөнгө /Ногоон байгууламж/	мян.төг	-	6,500.00	6,500.00	-	0.03
Хуримтлагдан элэгдэл	мян.төг	-	184.35	313.18	128.83	0.00
Бусад үндсэн хөрөнгийн цэвэр дүн	мян.төг	-	6,315.65	6,186.82	(128.83)	0.05
Үндсэн хөрөнгийн балансын дүн		18,798,357.79	18,855,453.55	18,903,075.99	47,622.44	100.00
Үндсэн хөрөнгийн элэгдлийн нийт дүн		5,584,309.82	6,042,077.02	6,352,977.02	310,900.00	100.00
Үндсэн хөрөнгийн цэвэр дүн		13,214,047.97	12,813,376.53	12,650,098.97	(263,277.56)	100.00

2023 оны жилийн эцсийн байдлаар үндсэн хөрөнгийг бүтцээр нь авч үзвэл 61.08 хувийг барилга байгууламж, 2.58 хувийг тээврийн хэрэгсэл, 35.86 хувийг машин тоног төхөөрөмж, компьютер, 0.43 хувийг тавилга эд хогшил, 0.05 хувийг бусад үндсэн хөрөнгө тус тус эзэлж байна. Үндсэн хөрөнгөд 2023 онд 6,042.07 сая төгрөгийн элэгдэл тооцож бүртгэсэн ба хөрөнгийн элэгдэл балансын тооцооллоор 32.04 хувьтай, элэгдлийг шулуун шугамын аргаар тооцож байгуулсан байна.

2024 оны эхний хагас жилийн байдлаар 61.60 хувийг барилга байгууламж, 2.42 хувийг тээврийн хэрэгсэл, 35.52 хувийг машин тоног төхөөрөмж, компьютер, 0.41 хувийг тавилга эд хогшил, 0.05 хувийг бусад үндсэн хөрөнгө тус тус эзэлж байна. Тайлант 2024 оны эхний хагаст 18,903.07 сая төгрөгийн балансын үнэтэй, 6,352.97 сая төгрөгийн хуримтлагдан элэгдэлтэй, 12,550.09 сая төгрөгийн үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгөтэйгээр үйл ажиллагаа явуулсан байна.

Нэмэгдсэн, хасагдсан үндсэн хөрөнгө болон түүний эрх зүйн талаар: Үйлдвэрийн газар нь үндсэн хөрөнгө олж бэлтгэхдээ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу бэлтгэдэг.

2023 онд үйлдвэрийн газрын нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2.6 хувиар буюу 608.08 сая төгрөгөөр өссөнөөс үндсэн хөрөнгө 328.38 сая төгрөгөөр нэмэгдэж, 271.28 сая төгрөгөөр хасагдсан байна.

Үйлдвэрийн газрын 2023 оны байдлаар үндсэн хөрөнгийн ангилаал, хөдөлгөөн

Үндсэн хөрөнгийн ангилаал	Хэмжих нэгж	Үлдэгдэл 2022.12.31		Орлого		Зарлага		Үлдэгдэл 2023.12.31		Хувийн жин /%
		Тоо хэмжээ	Өртөг	Тоо хэмжээ	Өртөг	Тоо хэмжээ	Өртөг	Тоо хэмжээ	Өртөг	
Барилга байгууламжийн балансын үнэ	мян.төг	59	10,423,664.08	2	134,748.88	-	-	61	10,558,412.96	56.00
Хуримтлагдан элэгдэл	мян.төг	-	2,425,205.47	-	306,409.69	-	-	-	2,731,615.16	45.21
Барилга байгууламжийн цэвэр дүн	мян.төг	59	7,998,458.61	2	(171,660.81)	-	-	61	7,826,797.80	61.08
Машин тоног төхөөрөмжийн балансын үнэ /компьютер/	мян.төг	309	7,677,461.54	21	90,081.44	30	192,359.36	300	7,575,183.62	40.18
Хуримтлагдан элэгдэл	мян.төг	-	2,893,815.79	-	278,468.35	-	192,359.36	-	2,979,924.78	49.32
Машин тоног төхөөрөмжийн цэвэр дүн	мян.төг	309	4,783,645.75	21	(188,386.91)	30	-	300	4,595,258.84	35.86
Тээврийн хэрэгсэл балансын үнэ	мян.төг	7	570,763.46	1	84,784.66	1	75,000.00	7	580,548.12	3.08
Хуримтлагдан элэгдэл	мян.төг	-	191,788.96	-	66,602.62	-	7,966.05	-	250,425.53	4.14
Тээврийн хэрэгслийн цэвэр дүн	мян.төг	7	378,974.50	1	18,182.04	1	67,033.95	7	330,122.59	2.58

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

Тавилга эд хогшлын балансын үнэ	мян.төг	230	126,468.71	4	12,265.05	30	3,924.91	204	134,808.85	0.71
Хуримтлагдсан элэгдэл	мян.төг	-	73,499.60	-	10,352.51	-	3,924.91	-	79,927.20	1.32
Тавилга эд хогшлын цэвэр дүн	мян.төг	230	52,969.11	4	1,912.54	30	-	204	54,881.65	0.43
Бусад үндсэн хөрөнгө /Ногоон байгууламж/	мян.төг	-	-	1	6,500.00	-	-	1	6,500.00	0.03
Хуримтлагдсан элэгдэл	мян.төг	-	-	-	184.35	-	-	-	184.35	0.00
Бусад үндсэн хөрөнгийн цэвэр дүн	мян.төг	-	-	1	6,315.65	-	-	1	6,315.65	0.05
Үндсэн хөрөнгийн балансын дүн	мян.төг	605	18,798,357.79	29	328,380.03	61	271,284.27	573	18,855,453.55	100.00
Үндсэн хөрөнгийн элэгдлийн нийт дүн	мян.төг	-	5,584,309.82	-	662,017.52	-	204,250.32	-	6,042,077.02	100.00
Үндсэн хөрөнгийн цэвэр дүн	мян.төг	605	13,214,047.97	29	(333,637.49)	61	67,033.95	573	12,813,376.53	100.00

Үндсэн хөрөнгө нэмэгдсэн, хасагдсан эрх зүйн үндэслэлийг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- ТӨБЗГ-ын 2022-12-19-ний өдрийн 558 дугаар тогтоолоор баталсан үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 2023 оны хөрөнгө оруулалтаар 366.11 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн;
- ТӨБЗГ-ын 2023-11-23-ны өдрийн 604 дүгээр тогтоолоор 75.0 сая төгрөгийн балансын үнэ, 7.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий Дэү солар-55 голд маркийн экскаваторыг Өвөрхангай аймгийн "Хархорин ус суваг" ОНӨААТҮГ-ын балансаас балансад шилжүүлсэн;
- ТӨБЗГ-ын 2023-12-21-ний өдрийн 733 дугаар тогтоолоор үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой, 17 нэрийн нийт 60.83 сая төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 18.25 сая төгрөгөөр шинэчлэн үнэлсэн;
- ТӨБЗГ-ын 2023-12-21-ний өдрийн 746 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй 41 нэр төрлийн 261.40 сая төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгийг актлаж, данснаас хассан.

4.6.1. Барилга байгууламжийн талаар: Үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгийн барилга байгууламжийн дансанд 2023 оны жилийн эцсийн байдлаар 10,558.41 сая төгрөгийн балансын үнэтэй, 2,731.61 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 7,826.79 сая төгрөгийн цэвэр дүн бүхий барилга, байгууламж бүртгэлтэй байна. Тайлант 2024 оны эхний хагас жилийн байдлаар 18 нэрийн барилга, 43 нэрийн нийтийн эзэмшлийн байгууламжууд бүртгэлтэй байна.

Барилга, байгууламж дансны төрөл, хөдөлгөөн

Барилга байгууламж	Хэмжих нэгж	Үлдэгдэл 2022.12.31		Орлого		Үлдэгдэл 2023.12.31		Хувийн жин %/	Үлдэгдэл 2024.06.30	
		Тоо хэмжээ	Өртөг	Тоо хэмжээ	Өртөг	Тоо хэмжээ	Өртөг		Тоо хэмжээ	Өртөг
Барилга	мян.төг	17	943,324.57	1	119,510.00	18	1,062,834.57	10.07	18	1,062,834.57
Нийтийн эзэмшлийн байгууламж	мян.төг	42	9,480,339.51	1	15,238.88	43	9,495,578.40	89.93	43	9,541,746.34
Дүн		59	10,423,664.08	2	134,748.88	61	10,558,412.97	100.00	61	10,604,580.91

Барилга байгууламжийн дансны бүтцийг авч үзвэл 10.07 хувь буюу 1,062.83 сая төгрөгийн хөрөнгийг барилга, 89.93 хувь буюу 9,495.57 сая төгрөгийг нийтийн эзэмшлийн авто зогсоол, шугам хоолой, байгууламжууд эзэлж байна. Тайлант онд үйлдвэрийн газрын 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, худалдан авалтын төлөвлөгөөний дагуу албан тушаалын байр буюу 62.9м2 3 өрөө орон сууцыг 119.51 сая төгрөгөөр, 13,238.88 сая төгрөгөөр цамхагт гэрэлтүүлгийн багц ажил, 2.0 сая төгрөгийн услалтын системийн ажлыг хийж гүйцэтгэн данс бүртгэлдээ тусгасан байна.

4.6.2. Тээврийн хэрэгслийн талаар: Үйлдвэрийн газрын тээврийн хэрэгслийн дансанд 2024 оны эхний хагас жилийн байдлаар 7 ширхэг 580.54 сая

төгрөгийн автомашин механизм бүртгэлтэй байна.

Тээврийн хэрэгслийн мэдээллийг хавсралтаар үзүүлбэл:

Д/д	Марк	Модель	Улсын дугаар	Арал. дугаар	Үйлд.он	Өнгө	Балансын үнэ /мян.төг/	Тайлбар
1	Hyundai	Sonata	6117ДГО	KMHEB41BAAA053278	2010	Хар	43,755.72	Хэвийн ашиглалттай
2	Toyota	Land Cruiser	0123ДГО	JTMHV05J804127772	2013	Хар	132,938.01	Хэвийн ашиглалттай
3	Hyundai	Starex	6039ДГО	KMJWAH7JP9U144251	2009	Мөнгөлөг саарал	29,517.09	Ашиглалтгүй 5 жил болсон
4	УАЗ	Фургон	6611ДГА	XTT374195K1209741	2018	Цагаан	32,716.54	Хэвийн ашиглалттай
5	Beiben	Автоцистерн	5195ДГН	LBZF46FB4PA001419	2023	Цагаан	218,000.00	Хэвийн ашиглалттай ТӨБЗГ-ын 2023-11-23 №604 дүгээр тогтоолоор балансаас балансад шилжүүлсэн.
6	Daewoo	Экскаватор	6731УБ	SL55VS34725	2005	Шар	-	
7	HENGWANG	Ковш	9449УР	64616	2019	Шар	47,999.76	Хэвийн ашиглалттай
8	Shandong	Автоцистернтэй чиргүүл	9449НА	LA99FRG35P0SCD437	2023	Саарал	75,621.00	Хэвийн ашиглалттай
580,548.12								

Үйлдвэрийн газрын тээврийн хэрэгслийн бүртгэлийг Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн нэгдсэн системийн бүртгэлтэй тулган шалгахад ТӨБЗГ-ын 2023 оны 604 дүгээр тогтоолоор балансаас балансад шилжүүлсэн Экскаватор, ДэүСолар-55 голд автомашин нь Өвөрхангай аймгийн “Хархорин Ус суваг” ОНӨААТҮГ-т шилжээгүй байна.



Үйлдвэрийн газрын хашаанд ашиглалтгүй 5 жил болсон Хьюндай Старекс автомашин байна. Цаашид илүүдэлтэй байгаа тус автомашиныг эдийн засгийн эргэлтэд оруулж, дуудлагын худалдаагаар худалдах буюу хэрэгцээ шаардлагатай төрийн өмчит хуулийн этгээдэд балансаас балансад шилжүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

4.7. Биет бус хөрөнгийн талаар: Үйлдвэрийн газар нь 2023 оны жилийн эцсийн байдлаар 1,704.27 сая төгрөгийн балансын үнэтэй, 335.91 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 1,368.36 сая төгрөгийн үлдэх өртөг/цэвэр дүн/-тэй биет бус хөрөнгийг ашиглан үйл ажиллагаа явуулсан байна.

Биет бус хөрөнгийн 2023 оны жилийн эцсээрх биет бус хөрөнгийн цэвэр дүнгийн 51.19 хувийг програм хангамж, 40.97 хувийг газар эзэших эрх, 7.83 хувийг бусад биет бус хөрөнгө эзэлж байна.

Биет бус хөрөнгийн хөдөлгөөнийг хүснэгтээр харуулбал:

Биет бус хөрөнгийн ангилал	Хэмжих нэгж	Үлдэгдэл 2022.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	Үлдэгдэл 2023.12.31	Хувийн жин %/
Компьютерийн программ хангамж	мян.төг	955,520.05	1,947.00	1,636.36	955,830.69	56.08
Хуримтлагдсан хорогдол	мян.төг	209,122.65	47,863.80	1,636.36	255,350.09	76.02
Цэвэр дүн	мян.төг	746,397.40	(45,916.80)	-	700,480.60	51.19
Газар эзэмших эрхийн балансын үнэ	мян.төг	560,685.44	-	-	560,685.44	32.90
Хуримтлагдсан хорогдол	мян.төг	-	-	-	-	-
Газар эзэмших эрхийн цэвэр дүн	мян.төг	560,685.44	-	-	560,685.44	40.97
Бусад биет бус хөрөнгийн балансын үнэ	мян.төг	197,210.47	54,034.72	63,484.79	187,760.40	11.02
Хуримтлагдсан хорогдол	мян.төг	117,414.73	26,636.10	63,484.79	80,566.04	23.98
Бусад биет бус хөрөнгийн цэвэр дүн	мян.төг	79,795.74	27,398.62	-	107,194.36	7.83
Үндсэн хөрөнгийн балансын дүн	мян.төг	1,713,415.96	55,981.72	65,121.15	1,704,276.63	100.00
Үндсэн хөрөнгийн элэгдлийн нийт дүн	мян.төг	326,537.38	74,499.90	65,121.15	335,916.13	100.00
Үндсэн хөрөнгийн цэвэр дүн	мян.төг	1,386,878.68	(18,518.18)	-	1,368,360.40	100.00

2024 оны эхний хагас жилийн байдлаар 1,704.77 сая төгрөгийн балансын үнэтэй, 373.32 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 1,331.45 сая төгрөгийн үлдэх өртөг /цэвэр дүн/-тэй биет бус хөрөнгийг ашиглан үйл ажиллагаа явуулсан байна.

4.7.1. Байгууллагын эзэмшил газрын талаар: Үйлдвэрийн газар нь 2024 оны эхний хагас жилийн байдлаар 3 нэр төрлийн газар эзэмших эрхийн Гэрчилгээ бүхий 61,573 м², 560.68 сая төгрөгийн балансын үнэ бүхий газрыг газар эзэмшүүлэх гэрээний дагуу эзэмшиж, ашиглаж байна.

Газрын мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Газрын байршил	Нийт талбай /м.кв/	Эрхийн улсын бүртгэлийн дугаар	Газар эзэмших шийдвэр, огноо дугаар	Санхүүгийн тайланд туссан дүн /мян.төг/
1	Газар -1	10,000	Э-0714002433	Замын-Үүд сумын Засаг даргын 2017-06-12, A/163 тушаал	
2	Газар-2	51,563	Э-0714002435	Замын-Үүд сумын Засаг даргын 2018-10-30, A/314 тушаал	492,496.00
3	Төмөр замын далан бүхий газар	9.686	Э-0714001520	Замын-Үүд сумын Засаг даргын 2020-10-27, A/307 тушаал	68,189.44
61,573					560,685.44

Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу 2018 онд дээрх газар эзэмших эрхийн 2 нэр төрлийн буюу 10.000 м.кв, 51.563 м.кв бүхий газрыг 492.50 сая төгрөгөөр үнэлж, санхүүгийн тайланд нэгтгэж тусгасан байна.

Цаашид тус 2 газрыг санхүүгийн тайланд салгаж бүртгэх нь зүйтэй.

4.8. Урт болон богино хугацаат өр төлбөрийн талаар: “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ нь 2023 онд 260,04 сая төгрөгийн өр төлбөртэй байсан бол тайлант 2024 оны эхний хагаст 33,034.24 сая төгрөгийн өр төлбөр нэмэгдэж, 9,101.52 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулан 282.34 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй болсон байна.

2024 оны эхний хагас жилийн эцсээрх өр төлбөрийн 43.58 хувийг урт хугацаат зээл, 56.42 хувийг богино хугацаат өр төлбөр эзэлж байна.

Үйлдвэрийн газрын 2023, 2024 оны эхний хагасын нийт өр төлбөрийн мэдээлэл

Өр төлбөрийн төрөл	Хэмжих нэгж	Үлдэгдэл 2022.12.31	Үлдэгдэл 2023.12.31	Зөрүү	Үлдэгдэл 2024.06.30	Зөрүү	Хувийн жин %/
Богино хугацаат өр төлбөр	мян.төг	46,361.72	135,373.76	89,012.04	159,306.47	23,932.71	56.42
Урт хугацаат өр төлбөр	мян.төг	107,532.96	124,669.70	17,136.74	123,036.49	(1,633.21)	43.58
Нийт өр төлбөрийн дүн		153,894.68	260,043.46	106,148.78	282,342.96	22,299.50	100.00

Богино хугацаат өр төлбөрийн данс нь дансны өглөг, урьдчилж орсон орлого, нөөц данснаас бүрдэж байна. 2023 оны эцсээр дансны өглөг данс 3.84 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөртэй гарсан нь МЗХННУлаанбаатар төмөр зам 12 дугаар сарын цахилгааны төлбөрийн нэхэмжлэхийг 31-ний сүүлийн өдрийн тоолуурын заалтаар баталгаажуулж тасалбар болгон гаргадагтай холбоотой байна. Урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 131.5 сая төгрөг болсон нь арилжааны банкуудад байршуулсан хадгаламжийн гэрээнд заасан хугацааны хүүгийн орлогыг урьдчилж орсон орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой.

Үйлдвэрийн газар нь 2023 оны эхэнд хойшлогдсон татварын өр дансны үлдэгдэл 107.53 сая төгрөгөөс 124.7 сая төгрөг болж 17.2 сая төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл элэгдэл тооцоогүй зөрүү дүнгээр нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант 2024 оны эхний хагаст 1.6 сая төгрөгөөр хорогдож 123.03 сая төгрөг болсон байна. Урт хугацаат өр төлбөрийн дансанд санхүүгийн болон татварын зориулалттай хөрөнгийн элэгдлийн зөрүүг тусгасан байна.

Үйлдвэрийн газрын урт хугацаат өр төлбөрийн мэдээлэл

Урт хугацаат өр төлбөрийн төрөл	Хэмжих нэгж	Үлдэгдэл 2022.12.31 мян.төг	Нэмэгдсэн 2023.12.31	Үлдэгдэл Хорогдсон 2024.06.30	Үлдэгдэл Хувийн жин /%
Хойшлогдсон татварын өр төлбөр		107,532.96	17,136.74	124,669.70	1,633.21 123,036.49 100.00
Нийт өр төлбөрийн дүн		107,532.96	17,136.74	124,669.70	1,633.21 123,036.49 100.00

Хөрөнгийн дотоодын тооллогын талаар: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 72 дахь заалтын дагуу байгууллагын дотоодын тооллогыг зохион байгуулж, хугацаанд нь хийж баталгаажуулсан. Үндсэн хөрөнгийн эхний хагас жилийн тооллогыг гүйцэтгэх захирлын 2023-06-19-ний өдрийн A/53 дугаар тушаалаар 2021 оны 06 дугаар сарын 19-29-ний өдрийн хугацаанд, жилийн эцсийн тооллогыг гүйцэтгэх захирлын 2023-12-18-ны өдрийн A/58 дугаар тушаалаар 2023 оны 12 дугаар сарын 18-25-ны хугацаанд зохион байгуулж явуулсан байна. Тооллогын дүнг актаар баталгаажуулан холбогдох шийдвэрийг гаргасан байна. 2023 оны дотоодын тооллогын дүнгээр 20,599.73 сая төгрөгийн дүн бүхий үндсэн хөрөнгө, 271,266.74 сая төгрөгийн үнэ бүхий эргэлтийн хөрөнгө тоологдсон байна. Тооллогын дүнгээр илүүдэлтэй, дутагдсан шамшигдсан хөрөнгө гараагүй байна.


Цаашид тооллогын илтгэх худас, тайландаа акталж данснаас хасах хөрөнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Тухайлбал, хөрөнгийн тоо хэмжээ, балансын дүн, элэгдлийн хэмжээ, үлдэгдэл үнэ, тайлбар, тодруулга зэргийг хүснэгтээр хавсаргаж байх нь зүйтэй.

Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн талаар: “Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын захирлын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн A/20 дугаар тушаалаар өмч хамгаалах Байнгын зөвлөлийг дараахь бүрэлдэхүүнтэй томилсон байна. Үүнд:

1. Ерөнхий нягтлан бодогч;
2. Ерөнхий инженер;
3. Технологийн инженер;
4. Тооцооны нягтлан бодогч;
5. Лабороаторийн эрхлэгч

Өмч хамгаалах зөвлөлийн Байнгын зөвлөлийн бүрэлдэхүүнийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.4-т заасантай нийцэж байгаа ба

Зөвлөл нь 2023 онд 9 ажлыг төлөвлөн, тайлан гарган ажилласан байна. **Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ажлыг**



Дотоод хяналт шалгалт, түүний үр нөлөөний талаар: Үйлдвэрийн газрын дотоод хяналт хариуцсан ажилтан нь 2023, 2024 онд дотоод хяналт шалгалтын чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө боловсруулж, гүйцэтгэх захирлаар батлуулан ажилласан ба тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэн, шаардлагатай асуудлаар дүгнэлт хүргүүлэх, хариу тайлбар авах зэргээр идэвх зүтгэл гарган ажилласан ба үр дүн гарсан байна. Үйлдвэрийн газар дотоод хяналт хариуцсан 1 ажилтан ажиллаж байна. 2023 онд дотоод хяналт шалгалтын ажиллах журам боловсруулан ажиллаж дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан удирдамжийн дагуу гүйцэтгэсэн байна.

2023 онд компанийн эд хөрөнгө, касс, няравын бүртгэл, тооцоо, ашиглалт, бичиг хэргийн үйл ажиллагаа, хөдөлмөр эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны байдал, гэрээ, гэрээний хэрэгжилт, шилэн дансны мэдээллийн бүрдэлд хяналт шалгалтыг хэрэгжүүлэн ажиллаж, үр дүнгээр холбогдох ажилтнуудад албан шаардлага хүргүүлэн, биелэлтийг хангуюлан ажиллажээ.

Дотоод хяналт шалгалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлууд үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

ТАВ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

2023 оны худалдан авах ажиллагаа: “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ нь 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөг үндэслэн 2023 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг үйлдвэрийн газрын захирлаар батлуулсан байна.

Үйлдвэрийн газар нь 2023 онд 3,561.95 сая төгрөгийн 30 арга хэмжээ /бараа, ажил, үйлчилгээ/-г худалдан авахаар төлөвлөж гүйцэтгэлээр 25 арга хэмжээг 459.95 сая төгрөгөөр худалдан авалт хийгдэж, 2,984.4 сая төгрөгийн 5 арга хэмжээний худалдан авалт хийгдээгүй байна. Нийт 117.6 сая төгрөгийн хэмнэлт гарган худалдан авалт хийжээ.

Компанийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

Худалдан авах ажиллагаанд мердсэн журам, арга	Хэмжийх нэгж	Худалдан авах үйл ажиллагааны						Тайлбар
		Төлөвлөгөө	Хэрэгжилт	Хэмнэлт	Хэрэгжээгүй	Төсөвт	Тайлбар	
		төсөвт өртөг	тоо	гэрээний дүн	тоо	дүн	төсөвт өртөг	тоо
Нээлттэй тендер шалгаруулалтын журам	мян.төг	250,000.0	-	0	-	250,000.0	1	НТШ 2 удаа зарлаад амжилттай болж хэрэгжээгүй.
	мян.төг	160,000.0	3	85,800.0	1	74,200.0	-	1 оролцогч оролцож хэрэгжсэн.
	мян.төг	120,000.0		119,510.0	1	490.0	-	НТШ 2 удаа зарлаад амжилттай болж, ГШБ арга сонгосон.
Тендер шалгаруулалтын онцгой журам, Гэрээ шууд байгуулах арга	мян.төг	2,700,000.0	1	-	-	2,700,000.0	1	Тендер амжилттай болсон.
Тендер шалгаруулалтын онцгой журам, Харьцуулалтын арга	мян.төг	121,799.7	3	118,273.4	3	3,526.4	-	Хэрэгжсэн
Шууд худалдан авах	мян.төг	210,148.1	23	-	136,350.7	20	39,397.4	-
						34,400.0	3	З арга хэмжээний ХАА-г зогсоосон
Нийт дүн		3,561,947.8	30	459,934.1	25	117,613.8	2,984,400.0	5

Нээлттэй тендер шалгаруулалтын журмын дагуу 530.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 арга хэмжээг худалдан авахаар төлөвлөсөн байна.

Эдгээрээс хар тугалганы агуулга тодорхойлох тоног төхөөрөмж худалдан авах 250.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий худалдан авах үйл ажиллагааг 2 удаа зохион байгуулсан ч амжилтгүй болсон тул худалдан авалтыг зогсоосон, 160.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий автоцистерний чиргуулийн худалдан авалтад 1 оролцогч оролцож 85.8 сая төгрөгийн санал өгч шалгарсан бөгөөд ялагчтай гэрээ байгуулснаар хэрэгжсэн байна. Харин нээлттэй тендер шалгаруулалтын журмаар

төлөвлөсөн 120.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий албан тушаалын 1 ширхэг байр худалдан авах үйл ажиллагааг 2 удаа зарлаад амжилтгүй болсон тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.1.1, 30.4.3-ийг үндэслэсэн гэрээ шууд байгуулах аргаар худалдан авалтын үйл ажиллагааг 119.51 сая төгрөгөөр гүйцэтгэсэн байна.

Тендер шалгаруулалтын онцгой журмыг сонгож, 2,700.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий газрын тосны бүтээгдэхүүн худалдан авах үйл ажиллагааг тус үйлдвэрийн газар нь өөрийн орлого, үр ашгаа нэмэгдүүлэх зорилгоор /тусгай зөвшөөрөл авч/ зохион байгуулсан хэдий ч амжилтгүй болж хэрэгжээгүй байна.

Шууд худалдан авах аргаар 210.2 сая төгрөгийн 30 арга хэмжээг худалдан авахаар төлөвлөсөн бөгөөд үүнээс 25 арга хэмжээг 136.4 сая төгрөгөөр гүйцэтгэж, 39.4 сая төгрөгийн хэмнэлт гарган ажилласан бол 34.4 сая төгрөгийн 5 арга хэмжээ хэрэгжээгүй байна. Ерөнхий гэрээгээр худалдан авалт хийгдээгүй байна.

Худалдан авах арга хэмжээнд аливаа маргаан, гомдол гараагүй байна.

2024 оны худалдан авах ажиллагаа: ТӨБЗГ-ын 2023.12.21-ний өдрийн 705 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэн үйлдвэрийн газрын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан үйлдвэрийн газрын захираар батлуулж худалдан авах ажиллагааны цахим системд оруулан 2024.01.04-ний өдөр Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт албан бичгээр хүргүүлсэн байна.

Батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд 5000 тонн газрын тосны бүтээгдэхүүн борлуулж 1,088,031,500 төгрөгийн орлого /ашиг/ олохоор тусгагдсан бараа худалдан авах үйл ажиллагааг үйлдвэрийн газрын 2024 оны худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй баталсны улмаас нэмэлт оруулах саналыг Сангийн яам, ТӨБЗГ-т хүргүүлэн худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 удаа тодотгосон байна.

Тус үйлдвэрийн газар нь худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөний дагуу 2024 онд 776.6 сая төгрөгийн 25 тооны арга хэмжээ /бараа, ажил, үйлчилгээ/-г худалдан авахаар төлөвлөсөн байна.

2024 оны ХАА-ны төлөвлөгөө, эхний хагас жилийн байдлаарх гүйцэтгэл

ХАА-д мөрдсөн журам, арга	Хэмжих нэгж	Анхны төсөвт өртөг		Тодотгосон төсөвт өртөг		Хэрэгжсэн 2024.09.30		Хэрэгжээгүй 2024.09.30		Гэрээ байгуулсан 2024.06.30	
		дун	тоо	дун	тоо	дун	тоо	дун	тоо	дун	тоо
НТШ	сая.төг	368.00	2	12,348.00	5	8,279.76	2	3,368.00	3	-	0
ТШОЖ-ХА	сая.төг	227.56	5	227.56	5	167.03	3	58.00	2	167.00	3
ШХА	сая.төг	181.05	18	181.05	18	131.84	14	40.42	4	131.80	14
Нийт дун		776.61	25	12,756.61	28	8,578.63	19	3,466.42	9	298.80	17

Үйлдвэрийн газрын худалдан авах үйл ажиллагааны 2024 оны 776.6 сая төгрөгийн 25 арга хэмжээ /бараа, ажил, үйлчилгээ/-г худалдан авах төлөвлөгөөнд 11,980.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий газрын тосны бүтээгдэхүүн худалдан авах 3 арга хэмжээ нэмэгдэж нийт 12,756.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 28 арга хэмжээг зохион байгуулахаар тодотгосон байна.

Нийт худалдан авалтын төлөвлөгөөний гүйцэтгэлийг авч үзвэл 2024.06.30-ны өдрийн байдлаар бүгд 298.8 сая төгрөгийн 17 арга хэмжээг хэрэгжсэн байгаа бол 2024 оны 3-р улирлын байдлаар 8,578.6 сая төгрөгийн үнэ бүхий 19 арга

хэмжээ хэрэгжсэн, 3,466.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 арга хэмжээ хэрэгжээгүй байгаа юм байна.

Үйлдвэрийн газрын хэрэгжүүлээгүй 9 арга хэмжээ нь НТШ-ын 3 арга хэмжээ, ТШОЖ-ын харьцуулалтын аргаар зарласан 2 арга хэмжээний шалгаруулалтыг 2-3 удаа зарлаад амжилтгүй болсон, албан конторын байр худалдан авах тендер шалгаруулалт амжилтгүй болоод байгаа тул түүнд авах зөөврийн компьютер, хэвлэх хувилах төхөөрөмж, тавилга эд хогшил авах ШХА-ын 2 арга хэмжээг хэрэгжүүлээгүй байгаа бол галын дохиоллын тоног төхөөрөмжийн их засвар, даралт хэмжигч /5000м3-ын сав/, цахилгаан щитний хийн хаалт, галын шар дохиолол худалдан авах 2 арга хэмжээ хийгдээгүй байна.

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ нь “Бүх төрлийн шатахууны бөөний худалдаа эрхлэх”, “Бүх төрлийн шатахуун импортлох” тусгай зөвшөөрлийн дагуу үйлдвэрийн газрын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд тусгасан ашиг орлогоо нэмэгдүүлэх ажлын хүрээнд газрын тосны бүтээгдэхүүн худалдан авах, борлуулах ажлыг үйлдвэрийн газрын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 3 удаа нэмэлт оруулан тусгасан байна.

Үйлдвэрийн газрын 2024 оны ХХА-ны төлөвлөгөөний нэмэлт арга хэмжээний мэдээлэл

Д/д	ХХА-ны төлөвлөгөөний тодотол баталхыг хүссэн албан бичиг хүргүүлсэн огноо, дугаар	Тендер зарлагдан хугацаа	Тендер хүлээн авх эцсийн хугацаа	Цахим системд үр дүн нийтгэлсэн хугацаа	Орол- цог- чийн тоо	Гэрээ байгуулсан огноо	Гэрээ байгуулсан этгээдийн нэр	Төсөвт өртөг /сая.төг/	Гэрээний дүн /сая.төг/	Хэмнэлт, хэрэгжээгүй дүн							
1	ТӨБЗГ-т 2024.05.22-ны 70, Сангийн яаманд 2024.05.22-ны 71	5/31/2024	6/24/2024	6/27/2024	2	7/8/2024	Диби ойл ХХК	2,980.0	2,601.2	378.81							
2	ТӨБЗГ-т 2024.07.04-ний 85, Сангийн яаманд 2024.07.04-ний 84	7/9/2024	8/1/2024	8/5/2024	3	8/14/2024	Шунглай петролиум	6,000.0	5,678.6	321.42							
3	ТӨБЗГ-т 2024.08.08-ны 98, Сангийн яаманд 2024.08.08-ны 99	8/12/2024	8/30/2024	9/4/2024	2	Шунглай петролиум барааны тоо хэмжээний шаардлага хангагуй, НИК тендерийн уна төсөвт өртөгээхэд хатарсон тул тендер амжилтгүй									3,000.00	-	3,000.00
Дүн									11,980.0	8,279.8	3,700.24						

Тус үйлдвэрийн газар нь 2024 оны 3-р улирлын байдлаар 11,980.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий газрын тосны бүтээгдэхүүн худалдан авах нээлттэй тендерийг 3 удаа зарлаж 2 удаагийн тендерт 8,279.8 сая төгрөг гэрээ байгуулсан бол 1 тендер амжилтгүй болсон байна.

Үйлдвэрийн газрын ашиг орлогыг нэмэгдүүлэх зорилгоор газрын тосны бүтээгдэхүүн худалдан авч борлуулсан ажлын үр дүнгийн талаар товч авч үзлээ.

Үйлдвэрийн газрын 2024 онд газрын тосны бүтээгдэхүүн (бөөний борлуулалтын) худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл /3-р улирлын байдлаарх/

Тендер шалгаруулал- тын нэр	Газрын тосны бүтээгдэхүүний бөөний борлуулалт хийх бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн		Техникийн тодорхойлолт	Гүйцэтгэл			Үр дүн				
	Төлөвлөгөө төсөвт өртөг /сая.төг/	Төлөвлөгөө тоо хэмжээ /к.литр/		Нэгжийн барааны нэр /төгрөг/	Гэрээний дүн хэмжээ /к.литр/	Төлөвлөгөө тоо хэмжээ /к.литр/					
Газрын тосны бүтээгдэхүүн худалдан авах /дизелийн тулш/	2,980.0 6,000.0 3,000.0	5,000.0	1000.0 2000.0 1000.0	Зуны дизелийн Роснефть энгийн дизель	2950 2,800 2,600	1,010.2 2,142.9 1,153.9	2,601.2 5,678.6 -	1,010.2 2,112.9 -	2727.5 5662.5 -	1,010.2 2,112.9 -	114.8 57.6 -
Дүн	11,980.0	5,000.0	4,000.0		4,306.9	8,279.8	3,123.0	8,390.0	3,123.0	172.4	

Тус үйлдвэрийн газрын зорилтот түвшний төлөвлөгөөнд 5000.0 тонн газрын тосны бүтээгдэхүүний бөөний борлуулалт хийхээр тусгагдсан бөгөөд тендерийн баримт, мэдээллээс үзвэл нийт 4000.0 тонныг худалдан авахаар тендер зарласан бол техникийн тодорхойлолтоор 4,306.9 тонн авахаар тусгасан тус тус барааны тоо хэмжээг зөрүүтэй тусгасан байна.

Гүйцэтгэлээр эхний 2 худалдан авалтаар 8,279.8 сая төгрөгийн гэрээ байгуулан 3,123.0 тонн түлшийг худалдан авч 8,390.0 сая төгрөгөөр борлуулж 172.4 сая төгрөгийн ашиг олсон байна.

2024 оны газрын тосны бүтээгдэхүүн худалдан авалт, борлуулалтын мэдээлэл

Худалдан авалт /төгрөг/					
Д/д	Байгууллага	НБУ	Хэмжээ литр	Нийт дүн НӨАТ-тэй	НӨАТ-гүй дүн
1	Ди Би Ойл ХХК	2575	1,010,169.00	2,601,185,175.00	2,364,713,795.45
2	Шунхлай	2650	2,112,876.00	5,599,121,400.00	5,090,110,363.64
Нийт дүн			3,123,045.00	8,200,306,575.00	7,454,824,159.09

Борлуулалт /төгрөг/					
Д/д	Байгууллага	НБУ	Хэмжээ литр	Нийт дүн НӨАТ-тэй	НӨАТ-гүй дүн
1	Гүнзэгэстэй	2700	1,010,169.00	2,727,456,300.00	2,479,505,727.27
2	Магнайтрейд	2680	989,266.00	2,651,232,880.00	2,410,211,709.09
3	Гүн ойл ХХК	2680	250,760.00	672,036,800.00	610,942,545.45
4	Би энд юу майн ХХК	2680	436,410.00	1,169,578,800.00	1,063,253,454.55
5	ЭРЧУ	2680	436,440.00	1,169,659,200.00	1,063,326,545.45
Нийт дүн			3,123,045.00	8,389,963,980.00	7,627,239,981.82
Ашиг				189,657,405.00	172,415,822.73

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ нь 2023 онд 6000.0 тонн газрын тосны бүтээгдэхүүний бөөний борлуулалт хийхээр төлөвлөсөн хэдий ч хэрэгжүүлж чадаагүй бол 2024 онд Ди Би Ойл ХХК болон Шунхлай компаниас гүйцэтгэлээр 8,200.3 сая төгрөгийн худалдан авалт хийж, дээр дурдсан 5 компанийд 8,389.96 сая төгрөгөөр борлуулж нийт 189.7 сая төгрөгийн ашиг олсон байна.

ЗУРГАА. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХАРЭГЖИЛТИЙН ТАЛААР:

6.1. Өмнөх хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2022 онд компанийн 2021 оны байдлаарх санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийж, “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” 2023-05-02-ны өдрийн 168 дугаар тогтоолыг хүргүүлсэн байна. Тогтоолын гол заалтуудыг дараах байдлаар хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

1. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ нь “Бүх төрлийн шатахууны бөөний худалдаа эрхлэх”, “Бүх төрлийн шатахуун импортлох” тусгай зөвшөөрлийн дагуу үйлдвэрийн газрын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд газрын тосны бүтээгдэхүүний бөөний борлуулалт хийхээр тусгаж, гүйцэтгэлээр 8,279.8 сая төгрөгийн гэрээ байгуулан 3,123.0 тонн түлшийг худалдан авч 8,390.0 сая төгрөгөөр борлуулж 172.4 сая төгрөгийн ашиг олсон байна.

2. Монгол Улсын шатахууны нөөцийг хадгалах талаар төрийн байгууллагад хандаж шийдвэрлүүлэн, төрийн өмчийн өгөөжийг нэмэгдүүлэх асуудлаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон холбогдох төрийн байгууллагад хандсан боловч шийдэгдээгүй байна.

3. Шалгалтаар мөнгөн хөрөнгөтэй (анхан шатны баримтын бүрдэл дутуу) 650.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй зөрчил дутагдал илэрснийг давтан гаргаагүй ажилласан байна.

2022 оны аудитын тайлангаар: “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2022 оны санхүүгийн тайланд “Уваа-Уул аудит” ХХК аудит хийж, “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгчээ.

Аудитаар үндсэн хөрөнгийн данстай холбоотой, тодруулга тайлантай холбоотой 2 зөрчил илэрсэнд зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн байна.

2023 оны санхүүгийн тайланд “Ашид баланс аудит” ХХК аудит хийж, “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн бөгөөд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах 2 зөвлөмж өгснөөс бүрэн хэрэгжсэн байна гэж дүгнэжээ.

ДОЛОО. БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023-05-16-ны өдрийн 200 дугаар тогтоолоор “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Захирал Г.Гансүхтэй байгуулсан Онцгой нэхцэл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Сайн” гэж дүгнэж гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн бол Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024-04-18-ны өдрийн 156 дугаар тогтоолоор үйлдвэрийн газрын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Захирал Г.Гансүхтэй байгуулсан Онцгой нэхцэл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Сайн” гэж дүгнэсэн байна.

Өмч эзэмшүүлэх гэрээний талаар: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай 2023/ДГА/14-0202 дугаартай Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулан ажиллаж, 2023 онд 96 хувь буюу “Сайн” үнэлгээ авсан байна.

Гэрээний дүнгээр Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал хэсгээс оноо хасагдсан байна.

НАЙМ. САНАЛ ДҮГНЭЛТ, ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ

Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламжийг газрын тосны бүтээгдэхүүний импортын хоёр дахь эх үүсвэр бий болгох зорилгоор Замын-Үүдэд, ТАСИС хөтөлбөрийн хүрээнд буцалтгүй тусламжаар, ХБНГУ-ын компани нь олон улсын стандартын дагуу төлөвлөж, орчин үеийн техник технологи, үйл ажиллагааны нэгдсэн систем бүхий тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглож барьсан бөгөөд энэ нь Монгол улсын анхны иж бүрэн газрын тосны байгууламж байна.

Харин Замын-Үүдэд хувийн хэвшлийн газрын тосны салбарын 2 компани ижил төрлийн үйл ажиллагаа эрхлэх болсон нь тус үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд шууд нөлөөлөл үзүүлж байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 558, 2023 оны 705 дугаар тогтоолоор “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын 2023, 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Гүйцэтгэлээр 2023 онд 3,716.64 сая төгрөгийн орлого олж, 2,425.66 сая төгрөгийн зардал гарган, тайлант хугацаанд 1,157.28 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардлыг 0.65 төгрөг байна.

Гүйцэтгэлээр 2024 оны эхний хагас жилээр 2,759.51 сая төгрөгийн орлого олж, 1,496.58 сая төгрөгийн зардал гарган, тайлант хугацаанд 1,137.76 сая төгрөгийн

цэвэр ашигтай ажилласан байна. Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардлыг 0.54 төгрөг болгон бууруулж цэвэр ашгийг төлөвлөснөөс 278.09 сая төгрөг буюу 32.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ нь газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах үндсэн чиг үүргийн дагуу орлого олдог бөгөөд 2023 онд “Бүх төрлийн шатахууны бөөний худалдаа эрхлэх”, “Бүх төрлийн шатахуун импортлох” тусгай зөвшөөрөл авч, үйлдвэрийн газрын чөлөөт мөнгөн хөрөнгийг эргэлтэд оруулан ашиг орлого нэмэгдүүлэх газрын тосны бүтээгдэхүүний бөөний борлуулалт хийх ажлыг төлөвлөж эхэлсэн байна.

“Сод Монгол” ХХК болон үйлдвэрийн газрын орлогын 90 орчим хувийг бүрдүүлдэг гол үйлчлүүлэгч “Лекс Ойл” ХХК-дад шингэн түлш шилжүүлэн ачих, хадгалах ижил төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгож өрсөлдөгч бий болсон мөн ОХУ-аас импортлох шингэн түлшний үнэ БНХАУ-аас импортлох түлшнээс хямд бөгөөд нийлүүлэлт хэвийн байгаагаас Замын-Үүдэд шингэн түлш шилжүүлэн ачилтын тоо эрс буурсан зэрэгтэй холбоотойгоор зөвхөн шингэн түлш шилжүүлэн ачих, хадгалах үндсэн чиг үүрэгтэй, томоохон байгууламжтай тус үйлдвэрийн газрын хувьд үйл ажиллагаа нь хумигдсан байдалтай байгаа бөгөөд ийм тохиолдолд хэрхэн ажиллах урт хугацааны бизнес төлөвлөгөөгүй ажиллаж байгаад дүгнэлт хийх шаардлагатай байна.

Тус үйлдвэрийн газар нь цар тахлын үед Монгол Улсад үүссэн шатахууны хомсдолыг арилгахад томоохон үүрэг гүйцэтгэсэн бөгөөд цаашид ОХУ-аас импортлох шингэн түлшний үнэ өсөх, хомдох, бусад гэнэтийн тохиолдлуудад ажиллах газрын тосны импортын хоёр дахь эх үүсвэр болох хэдий ч одоогийн байдлаар “Лекс Ойл” ХХК-ийн түлш хадгалалт удаан хугацаанд үргэлжлэхгүй тул газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний /лабораторийн/ орлого, чөлөөт мөнгөн хөрөнгийн хүүгийн орлогоос гадна цаашид нэмэлт орлого олох, зардлаа нехэж ажиллах зорилгоор өөрсдийн нөөц боломжкоо ашиглан газрын тосны салбарын хувийн компаниудтай зэрэгцэн бүх төрлийн шатахуун импортлох, бөөний худалдаа эрхлэх эрсдэлтэй ажлыг эхлүүлэн 189.7 сая төгрөгийн ашиг олж одоогоор үр ашигтай ажиллаж байна.

Гэсэн хэдий ч “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын 2023 он, 2024 оны эхний хагас жилийн удирдлага, санхүү, аж ахуй, здийн засгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад журам зааврыг зөрчин **35.5 сая төгрөгийн зөрчил дутагдал гаргасан байна.**

1. Хуулийн этгээдийн үйл ажиллагаатай холбоотой дутагдал: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019-11-29-ний өдрийн “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ-ын дүрэмд нэмэлт оруулах тухай 503 дугаар тогтооолоор “...бөөний болон жижиглэн худалдаа эрхлэх” чиг үүргийг нэмж, дүрэмд тусгах зөвшөөрөл олгож, дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт зохих журмын дагуу бүртгүүлэх үүрэг өгсөн хэдий ч бүртгүүлсэн баримт алга байна.

2. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой зөрчил: **2.1.** Монгол Улсын Төсвийн тухай хуульд заасан Төсвийн захирагч санхүү, төсвийн зохистой удирдлагын зарчмыг хэрэгжүүлэхдээ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн **30.3-д**

“Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно”, Хэмнэлтийн тухай хуулийн 4.2.6-д “үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх,” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж, “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж ТӨҮГ нь 2023 онд 18 ажилтанд нийт 38.6 сая төгрөгийн зээлийг “ээлжийн амралтын урьдчилгаа мөнгө” нэрээр олгож, авлагá үүсгэж ажилласан байна.

2.2.Үр дүнгийн урамшууллыг үр дүн, өгөөжид үндэслээгүй дутагдал: Үйлдвэрийн газрын 2022-2024 онд хэрэгжүүлэх хамтын гэрээний 2.12-т ”Байгууллагын жилийн эцсийн ажлын үр дүнг харгалзан тухайн жилийн ашгаас хамаарч ажилтанд жилийн ажлын үр дүнг харгалзан 1-6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг тухайн жилийн эцэст олгоно.”, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7.2.3 ”Байгууллага тухайн жилд ашигтай ажилласан эсэхээс хамааран ажилчдад жилийн ажлын үр дүнгийн урамшууллыг тайлангийн хурлаар шийдвэрлэн олгож болно. Нэмэгдлийг олгоходо “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын “Жилийн ажлын үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох журам”-ыг баримтална” гэсэн заалтыг үндэслэн захирлын 2023.05.10-ны A/49 дугаар тушаалаар 2022 оны үр дүнгийн цалин 189.5 сая төгрөгийг, 2024.01.25-ны өдрийн A/07, 2024.04.16-ны өдрийн A/15 дугаар тушаалаар 2023 оны үр дүнгийн цалин 76.6 сая төгрөгийг тус тус олгосон ба үр дүнгийн цалин олгох хугацааг нийт ажилчдад 5 сараар тооцжээ.

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачилт, хадгалалтын тоо хэмжээ, орлого, зарлагыг сүүлийн 5 жилийн зорилтот түвшний гүйцэтгэлээр гаргаж харахад 2022 он, 2023 онд бүтээгдэхүүний тоо хэмжээ орлого, цэвэр борлуулалт буурсан, зардал өссөн үзүүлэлттэй байна.

Үйлдвэрийн газрын 2019-2023 оны зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Зорилтот түвшний гүйцэтгэл /сүүлийн 5 жилийн байдлаарх/				
			2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
<i>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, түгээлт борлуулалт</i>							
1	Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих	тонн	94,835	80,832	126,691	68,639	60,768
	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах	тонн	11,944	17,070	18,750	9,691	10,576
2	Нийт орлого Үүнээс: Цэвэр борлуулалт Дансны хүү, бусад орлого	мян.төг	3,240,069 3,098,352 141,717	4,633,385 4,301,318 332,067	4,817,016 4,156,344 660,672	3,579,932 2,921,231 658,701	3,716,649 2,852,260 864,388
3	Нийт зардал	мян.төг	1,299,107	1,538,419	1,905,302	2,124,971	2,425,666

Иймд ажилтны үр дүнгийн урамшуулал тооцох сарыг үйлдвэрийн газрын үндсэн үйл ажиллагаа түүний тогтвортой байдал, үр өгөөж, ашигт ажиллагаа, ажилтнуудын ачаалал, ажлын үр дүн, бүтэээмжтэй уялдуулан тогтоож төрийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлж ажиллахад анхаарч ажиллах нь зүйтэй.

3.Бүтээгдэхүүний үнэ тариф, эрх зүйн акттай холбоотой дутагдал:

3.1.“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ нь газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих, хадгалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ үнэ тарифыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.9 /Захирлын эд хөрөнгийн эрх, үүрэг/-д “улсаас хатуу тогтоосноос бусад бүтээгдэхүүн, ажил

үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох” гэж заасны дагуу үйлдвэрийн газрын даргын тушаалаар тогтоож, өөрчлөлт оруулж байна.

Харин үйлдвэрийн газрын Дүрмийн 4.3-т “Үйлдвэрийн газрын шилжүүлэн ажилтын болон хадгалалтын үнэ тарифыг төрийн захиргааны холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр захирлын тушаалаар батална” гэсэн байгаа тул өөрчлөлт оруулах тухай бүр зөвшилцж байх нь зүйтэй.

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын 2022-2024 оны бүтээгдэхүүний үнийн тариф, өөрчлөлт /төгрөгөөр/

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Кэмжих нэгж, үзүүлэлт,	Тарифын үнэ ТӨҮГ-ын захирлын				Тарифын өөрчлөлт
			2022-01-03-ны едрийн А/01 тушаалаар	2023-05-31-ний едрийн А/51 тушаалаар	2024-01-02-ны едрийн А/02 тушаалаар		
1	Газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачилт /1 тонн/	Цариг хооронд, саванд	тонн	15,000.0	15,000.0	18,000.0	3,000.0
2	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалалт /1 тонн/	сав	1 хоног	700.0	700.0	770.0	70.0
3	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалалт 2000м ³ -ын сав		сар	30,000,000.0	30,000,000.0	36,000,000.0	6,000,000.0
4	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалалт 3000м ³ -ын сав	Нарийн царигаар нийлүүлэгдэх	сар	45,000,000.0	45,000,000.0	54,000,000.0	9,000,000.0
5	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалалт 5000м ³ -ын сав		сар	75,000,000.0	75,000,000.0	90,000,000.0	15,000,000.0
6	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалалт 2000м ³ -ын сав		сар	-	26,000,000.0	36,000,000.0	10,000,000.0
7	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалалт 3000м ³ -ын сав	Өргөн царигаар нийлүүлэгдэх	сар	-	39,000,000.0	54,000,000.0	15,000,000.0
8	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалалт 5000м ³ -ын сав		сар	-	65,000,000.0	90,000,000.0	25,000,000.0

3.2.Гэрээ, дүрэм журмын уялдааг хангаагүй дутагдал: Газрын тосны салбарт 2022-2024 онд хэрэгжүүлэх хамтын хэлэлцээрийг Уул уурхайн яам, ажил олгоч, ажилтны төлөөлөл оролцон 3 жил хүчин төгөлдөр байхаар гарын үсэг зурж, 2021.12.24-ний өдөр Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд бүртгүүлсэн байна. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ нь 2022-2024 онд хэрэгжүүлэх хамтын гэрээг байгууллагын Үйлдвэрчний эвлэлийн хороотой 2022.07.29-ний өдөр байгуулж, 2022.08.03-д Дорноговь аймгийн Замын-Үүд суманд бүртгүүлсэн байна.

Салбарын хамтын гэрээний 3.3.1-т “Эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэвэл 40 хувиас доошгүй” байхаар заасан бол байгууллагын хамтын хэлэлцээрийн 2.2-т “Эзгүй байгаа ажилтны ажил үүргийг ажлын 10 хоногоос дээш хугацаагаар орлон гүйцэтгэсэн тохиолдолд үндсэн цалингийн 30 хүртэлх хувиар нэмэгдэл олгоно”, байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7.1.6-д “....буюу түр орлон гүйцэтгэсэн тохиолдолд ажилтанд тухайн албан тушаалын цалингын 40 хүртэлх хувийн нэмэгдлийг захирлын тушаалаар” олгохоор тус тус заасан байгаа нь хоорондоо уялдаагүй, зөрүүтэй тогтоосон мөн салбарын хамтын хэлэлцээрийн 3.4-т “..мэргэшсэн инженер, зөвлөх инженер, докторын зэргийн нэмэгдэл” гэж заасан байхад байгууллагын хамтын гэрээний 2.10.2-т “....нягтлан бодогч /гэх мэт-/ийг оруулан баталсан байна.

Салбарын хамтын гэрээ, бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын дотоодод мөрдөх зарим эрх зүйн баримтуудын хоорондын уялдааг хангаж байгууллагын хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журмыг боловсруулж байх шаардлагатай.

4.Худалдан авах үйл ажиллагааны талаарх дутагдал: 4.1.ТБОНӨБАУХА тухай хуулийн 50.1-д нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт

өртөгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил үйлчилгээ худалдан авахаас бусад тохиолдолд үнэлгээний хороо байгуулахаар заасныг зөрчин шууд худалдан авалтуудад үнэлгээний хороо байгуулан ажилласан байна. Мөн 2023 онд байгуулагдсан бүх тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд хөндлөнгийн гишүүнээр Ч.Отгонбаяр, Г.Өлзийжаргал нарыг оролцуулсан байгааг анхаарч тухайн салбарт мэргэшсэн ажилтан ажиллуулж сэлгэж байх нь зүйтэй.

4.2.Авто сэлбэг, масло тосол худалдан авалт, засвар үйлчилгээний 8,290.000 төгрөгийн тендерт бараа бүтээгдэхүүний барааны үнийн задаргааг тодорхойлоогүй, захиалагч, оролцогчтой харилцсан албан бичиг бүрэн хавсаргаагүй буюу үнийн санал хүргүүлсэн 1 албан бичиг байгаа бөгөөд харьцуулалт хийх бусад этгээдийн албан бичиг болон тендерт ялагчид хүргүүлсэн албан бичиг байхгүй, санал ирүүлсэн хэдэн этгээд байгаа талаар тэмдэглэлд огт дурдаагүй, хурлын тэмдэглэл, худалдан авах гэрээ байхгүй гэх зэргээр хуулийн 48. 4 дэх заалтын хэрэгжилтийг хангаагүй байна. /Ж нь: Тоног төхөөрөмж, барилга байгууламжийн засвар үйлчилгээний тендерийн захиалагч, оролцогчдын харилцсан албан бичгийг, архивын баримт бичиг хадгалах сейф, хийн ангижуулагчийн хөвүүр, тоног төхөөрөмж, барилга байгууламжийн засвар үйлчилгээ худалдан авах захиалагч, оролцогчийн албан бичиг хавсаргаагүй гм/.

4.3.Мод тарих, хашаажуулах, услалтын систем, хүлэмж хийх ажил ШТШАБ/202312010 дугаартай тендерийн урилгатай. Энэхүү тендерийн батлагдсан баримт бичгийн техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага хэсэгт 4x8 ногоо тарих хүлэмж барих, ногооны үрслэгээ хийх, 100 ш улиас мод, 5 тн ёмкость бүхий усалгааны бүрэн систем хийхээр заасан хэдий ч 2023-03-07-д үнийн санал авах албан бичгийн хавсралтаар хайлаас 200 ш, улиас 20 ш, шар хуайс 100 ш, голт бор 30 ш нийт 350 ш мод тарих, усалгааны систем, 2 тн усан сан авч, бэлэн байгаа 5 тн ёмкост усалгааны системд холбож суурилуулах ажлын /зөрүүтэй/ даалгавар боловсруулж 2 байгууллагад хүрүүлсэн байна.

Санал хүргүүлсэн “Нутгийн арван зүйлс” ХХК-иас 2023-04-12-д голт бор мод 15 ширхэг нэмэгдүүлэн нийт 365 мод тарих ажлыг 12,0 сая төгрөгөөр хийх үнийн санал ирүүлсэн байна. Тус байгууллага хүлэмж худалдаалах, барих үйл ажиллагаа эрхэлдэггүй тул хүлэмж барих үнийг хассан шаардлагад нийцээгүй санал ирүүлснийг хүлээн зөвшөөрч уг ажлыг хийлгэсэн байна.

4.4. Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан цахим хуудсанд тендерийн урилгыг зарлан мэдээлэх бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөгийн доод хязгаар 20.0 сая төгрөг байхаар заасан байхад тус үйлдвэрийн газар 2023 онд босго үнээс доогуур үнэтэй тендер бүрт тендерийн баримт бичиг боловсруулан үргүй зардал гаргаж байгааг анхаарах, мөн цахим дэлгүүрээс худалдан авалт зохион байгуулж байх;

5. Зөвшөөрөлгүй худалдан авалттай холбоотой зөрчил: Тус үйлдвэрийн газар нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 558 дугаар тогтооюур батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй нийт 6 нэр төрлийн 13.5 сая төгрөгийн барааг тодотгож зөвшөөрөл авалгүй худалдан авсан зөрчил гаргасан байна.

Үйлдвэрийн газрын 2023 оны ХО-ын төлөвлөгөөнд тусгаагүй, зөвшөөрөлгүй худалдан авалт /төгрөгөөр/

Д/д	Хөрөнгийн нэр	Дүн
1	Барилгын зураг /гараж/	4,034,727.3
2	Согтolt хэмжигч багаж Alcotest 6820	3,000,000.0
3	ГТБ-ний усанд уусах хүчил шүлт тодорхойлох төхөөрөмж pH meter Apera PH700	1,350,000.0
4	Ус халаагч бойлуур /50 литр, шүршүүрийн хамт Siominzi/	390,909.1
5	Инвертер /гүний худгийн цахилгаан/	800,000.0
6	Гүний худгийн насос 2023	2,018,900.0
7	Гүний худгийн насос 2023-2	1,881,818.2
Нийт дүн		13,476,354.5

ЕС.ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

9.1. Төрийн өмчит үйлдвэрийн газрын бизнес төлөвлөгөө боловсруулан батлуулах;

9.2. Үйлдвэрийн газрын Дүрмийн 4.3-т “Үйлдвэрийн газрын шилжүүлэн ажилтын болон хадгалалтын үнэ тарифыг төрийн захирагааны холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр захирлын тушаалаар батална” гэсэн байгаа тул өөрчлөлт оруулах тухай бүр зөвшилцэж байх;

9.3. Ашиглалтгүй илүүдэлтэй байгаа Хьюндай Старекс автомашиныг хэрэгцээ шаардлагатай төрийн өмчит хуулийн этгээдэд балансаас балансад шилжүүлэх аль эсвэл дуудлагын худалдаагаар худалдах тухай асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх;

9.4. Үйлдвэрийн газрын барилга байгууламж дансанд бүртгэлтэй иж бүрэн монгол гэр болон чингэлэг /40 тн улаан/- ийг бусад үндсэн хөрөнгө данс руу данс хооронд шилжүүлэх;

9.5. Монгол Улсын шатахууны нөөцийг үйлдвэрийн газрын шатахууны саванд хадгалах талаар холбогдох байгууллагад хандаж, шийдвэрлүүлэх, идэвх санаачлагатай ажиллах;

9.6. Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусlamжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх;

9.7. Хөдөлмөрийн тухай хууль, ТБОНӨТХ болон ТӨБЗГ-ын 2022 оны 184 дүгээр тогтоолоор баталсан “төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ыг мөрдөж ажиллах;

9.8. Салбарын хамтын гэрээ, бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын дотоодод мөрдөх зарим эрх зүйн баримтуудын хоорондын уялдааг хангаж байгууллагын хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журмыг боловсруулах, тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг оновчтой тогтоож байх;

9.9. Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон ажиллах;

9.10. ТБОНӨБАУХА тухай хууль түүнтэй холбогдон гарсан дүрэм журам, зааврыг мөрдлөг болгон ажиллах;

9.11. Үйлдвэрийн газарт мөрдөж байгаа журам, эрх зүйн актуудад дүн шинжилгээ хийж, шинэчлэн боловсруулах, үчингүй болгох ажлыг зохион байгуулах;

Цаашид шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх чиглэлээр удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах.

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгуулам” ТӨҮГ-ын санхүү эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, барагдуулах чиглэлээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолын төслийг танилцуулж байна.

Танилцаж зөвшөөрсөн:



Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч Ц.Түвшинзаяа

2014.12.11

Тайлан боловсруулсан:



Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагч Э.Ганчимэг



Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтэн, Санхүүгийн хяналт шалгалтын Улсын байцаагч Ч.Батчимэг

Танилцаж зөвшөөрсөн:



“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын захирал Г.Гансух

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын Ерөнхий нягтлан бодогч Б.Дэлгэрдалай

